



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2014.11.20 № 1315

танай _____ -ны № _____ -т

Г
УЛСЫН ИХ ХУРЛЫН ТӨСВИЙН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА
Ц.ДАВААСҮРЭН ТАНАА

Үндэсний аудитын газраас "Эрүүл мэндийн даатгалын сан, иргэний нэрийн дансанд хуримтлагдсан мөнгөн хөрөнгийн байдал"-д хийсэн аудитын тайланг хүргүүлж байна.

Хүлээн авч танилцана уу.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР




А.ЗАНГАД

Нийцлийн аудитын А5-бланк



МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ
АУДИТЫН ГАЗАР

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛ, ИРГЭНИЙ НЭРИЙН ДАНСАНД
ХУРИМТЛАГДСАН ХӨРӨНГИЙН БАЙДАЛ



Эрүүл мэндийн даатгал, Тэтгэврийн даатгалын нэрийн дансны тухай
хууль, тэдгээрийн үйл ажиллагаатай холбогдон гарсан журмын
хэрэгжилт хангалтгүй байна

Улаанбаатар хот
2014 он

Аудитын тайланг**Бэлтгэсэн:****Нийцлийн аудитын газар**

Дарга: Б.Алтанзул

Аудитын менежер:
З.АриунзаяаАхлах аудитор:
Л.Хонгорзул
Шинжээч:
Л.Нямтэмэр

2014 оны 9 дүгээр сар

Уг тайланг УАГ-ын
цахим хуудаснаас үзнэ үү:
www.audit.mnАудитын тайлантай
холбоотой асуудлаар
нэмж тодруулах, асууж
лаялах зүйл байвал 261729
дугаарын утас, 260949
дугаарын факсаар
харилцана уу.Хаяг: Үндэсний аудитын
газарЧингэлтэй дүүрэг,
Засгийн газрын 4 дүгээр
байр, Бага тойруу-3
Улаанбаатар-15160
Монгол Улс**АГУУЛГА**

Товчилсон үгийн тайлбар	2
Аудит хийх үндэслэл, зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт	3
Ерөнхий мэдээлэл	4
Бүлэг-1. Эрүүл мэндийн даатгалын сангийн бүрдүүлэлт зарцуулалт	6
1.1.ЭМДСЗ хуульд заасны дагуу ажиллаагүй, хууль тогтоомжийн зарим заалт хэрэгжихгүй байна	6
1.2. ЭМД-д иргэдийг бүрэн хамруулаагүйгээс сангийн орлого нэмж бүрдэх боломжийг алдсан байна	6-9
1.3. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний зардлыг журам зөрчин санхүүжүүлсэн, ЭМДС-ийн цахим мэдээллийн баазад даатгуулагчийн мэдээлэл зөрүүтэй бүртгэгдсэн байна	9-16
Бүлэг-2. ТДШНД-ны орлогын бүрдүүлэлт, хуримтлагдсан мөнгөн хөрөнгийн байдал	17
2.1.МУ-ын иргэнд нэрийн дансыг нээх үйл ажиллагааны хэрэгжилт хангалтгүй байна	17
2.2.ТДШНД-ны гарцааны үлдэгдэл тооцож бүртгэх ажил хангалтгүй байна	17-18
2.3.Ажил олгогчийн төлсөн шимтгэлийг нэрийн дансанд бүртгэж, хууль журмын дагуу хүүгийн орлогыг тооцдог байна	18
2.4.ТДШНД-д хуримтлагдсан мөнгөн хөрөнгө хийсвэрээр бүртгэгдэж байна	18-19
Бүлэг-3. Сангуудын үйл ажиллагаанд тавих хяналт	20
3.1. ЭМДС-ийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтын дүрмийн зарим заалтыг хэрэгжүүлээгүй, ТДШНД-ны тухай хуулийн хэрэгжилтэд тавих хяналт хангалтгүй байна	20
Дүгнэлт	21
Холбогдох байгууллагын санал	22-25
Зөвлөмж	26
Холбогдох байгууллагын саналд өгөх тайлбар	27
Хавсралтууд	28-29
Монгол Улсын Ерөнхий аудиторын тушаал	30

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ААН	Аж ахуйн нэгж
ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
БНД	Багануур дүүрэг
ИЭМДТХ	Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хууль
МУ	Монгол Улс
УИХ	Улсын Их Хурал
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
МСҮТ	Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв
НАГ	Нийслэлийн Аудитын Газар
НББТ	Нягтлан бодох бүртгэлийн тухай
НДЕГ	Нийгмийн Даатгалын Ерөнхий Газар
НДҮЗ	Нийгмийн Даатгалын Үндэсний Зөвлөл
НДХ	Нийгмийн Даатгалын Хэлтэс
НДС	Нийгмийн Даатгалын Сан
НДТХ	Нийгмийн даатгалын тухай хууль
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НХХС	Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн сайд
ӨОУА	Өвчний Олон улсын ангилал
ҮАГ	Үндэсний Аудитын Газар
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
СБД	Сүхбаатар дүүрэг
СС	Сангийн сайд
ТДШНД	Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн данс
ЭМДГ	Эрүүл мэндийн даатгалын газар
ЭМД	Эрүүл мэндийн даатгал
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан
ЭМДСЗ	Эрүүл мэндийн даатгалын салбар зөвлөл
ЭМС	Эрүүл мэндийн сайд
ЭМН	Эрүүл мэндийн нэгдэл

Аудит хийх үндэслэл, зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудит хийх үндэслэл: Аудитыг Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2014 оны “Аудитын сэдэв батлах тухай” 03 дугаар тогтоолыг үндэслэн Монгол Улсын Ерөнхий аудитороос 2014 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу төрийн аудитын хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийв.

Аудитын зорилт: Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хуулийн хэрэгжилтийг дор дурьдсан зорилтын хүрээнд шалгаж, дүгнэлт гарган, санал зөвлөмж боловсруулж, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдсэн болно. Үүнд:

1. Иргэний эрүүл мэндийн даатгалд хууль журмын дагуу шимтгэл төлсөн, даатгалын санг урьдчилан бүрдүүлсэн, эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээний зардлын төлбөрийг уг сангаас төлсөн байдал;
2. Тэтгэврийн даатгалд даатгуулсан иргэнд тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн данс нээх, уг дансны эхний үлдэгдэл, даатгуулагчийн төлсөн шимтгэл, хүүг тооцох, нэрийн данснаас тэтгэвэр тогтооход бэлэн эсэх;
3. Сангуудын үйл ажиллагаанд тавих дотоод хяналтын байдал.

Аудитын хамарсан хүрээ: Аудитаар ЭМДС-ийн үйл ажиллагааг 2013 онд хэрэгжүүлсэн НДЕГ, аймаг, нийслэлийн нийгмийн даатгалын хэлтэс болон холбогдох байгууллагыг хамруулан шалгалаа.

Аудитын арга зүй: Аудитад Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын арга зүйг ашиглан, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, лавлагаа авах, аудитын горимын дагуу нотлох зүйл цуглувулан судлах, нөхцөл байдлын шинжилгээ хийх зэрэг арга зүй, горимыг хэрэгжүүлж, аудитын дүн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд: Монгол Улсын 2013 оны Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай, Нийгмийн даатгалын тухай, Иргэний Эрүүл мэндийн даатгалын тухай, Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хуулиуд, УИХ, ЗГ-ын тогтоолууд болон эдгээр хууль, тогтоолыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гаргасан журам, аргачлал, бусад эрх зүйн актуудын холбогдох заалтыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав.

Аудитын стандартын талаарх мэдэгдэл: Аудитыг гүйцэтгэхдээ Төрийн хяналт шалгалтын стандарт, түүнийг хэрэгжүүлэх аргачилсан зөвлөмж, Гүйцэтгэлийн шалгалтын журам, Гүйцэтгэлийн аудитын гарын авлага, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийг мөрдэж ажиллалаа.

Аудитын дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох бусад мэдээлэл, шинжилгээ, судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

Ерөнхий мэдээлэл

Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д “Иргэний эрүүл мэндийн даатгал нь төр иргэн, хуулийн этгээдээс хуульд заасан журмын дагуу даатгалын шимтгэл төлж, даатгалын санг урьдчилан бүрдүүлэх, даатгуулагчдад эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээний зардлын төлбөрийг уг сангаас төлөх нийгэм, эдийн засгийн арга хэмжээ мөн” гэж тодорхойлсон байна.

МУЗГ-ЫН 2012 оны 195 дугаар тогтоолоор ажил олгогч, ажилтны ЭМД-ЫН шимтгэлийн хэмжээг сарын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын 4 хувь, төрөөс хариуцах иргэдийн ЭМД-ЫН шимтгэлийн хэмжээг сар бүр 670 төгрөгөөр, гадаадын иргэн харьяалалгүй хүний ЭМД-ЫН шимтгэлийн хэмжээг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 6 хувьтай тэнцүү байхаар тогтоосон байна.

ЭМДС-ийн 2013 оны батлагдсан болон тодотгосон төсвийг харуулбал:

/сая.төгрөг/

НДҮЗ-ийн тогтоол	Орлого	Зарлага
“Төсвийн хуваарь батлах тухай” 2012.12.03-ны 8 дугаар тогтоол	183,095.30	136,519.10
“Тодотгосон төсвийн хуваарь батлах тухай” 2013.11.25-ны 31 дүгээр тогтоол	202,330.10	131,444.00

Улсын хэмжээнд 2013 онд нийт 203,954.2 сая төгрөгийн эрүүл мэндийн даатгалын сангийн орлого бүрдүүлж, 125,636.0 сая төгрөгийг эрүүл мэндийн тусlamж үйлчилгээ, эмийн үнийн хөнгөлөлт, ЭМДС-ийн үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтын зардалд зарцуулж тайлант оны сангийн үлдэгдэл нь 78,318.2 сая төгрөг байна.

ЭМДС-ийн 2013 оны орлого, зардлын бүтцийг хүsnэгтээр харуулбал:

/сая

төгрөг/

Орлого			Зарлага		
Төрөл	Дүн	хувь	Төрөл	Дүн	хувь
Даатгалын орлого	185,164.6	90.79	Эмчилгээ, тусlamж үйлчилгээний зардал	106,667.9	84.91
Хүүгийн орлого	17,695.8	8.68	Сувилалд	4,343.5	3.46
Акт	590.3	0.29	Эмийн үнийн хөнгөлөлт	9,726.0	7.74
Хугацаандаа төлөөгүй алданги	308.2	0.15	Төлбөр зөрчлийн дүнгээс тооцсон урамшууллын зардал	31.9	0.03
Бусад	195.3	0.10	ЭМДС-ийн үйл ажиллагаа, ХО-ын зардалд	4,775.7	3.80
			Сангийн бусад зарцуулалт /шүүхийн шийдвэр гүйцэтгэл, буцаасан шимтгэл/	91.0	0.07
Нийт дүн	203,954.2	100.00	Нийт дүн	125,636.0	100.00

/Дэлгэрэнгүйг хавсралт 1, 2-оос үзэх үү/

НДҮЗ-ийн 2007 оны 6 дугаар тогтоолоор эрүүл мэндийн даатгалын сангийн 10 хувьтай тэнцэх хөрөнгийг ЭМД-ЫН Болзошгүй эрсдлийн нөөцөд үлдээж байхаар тогтоосон бөгөөд 2013 оны нөөцөд хуримтлуулах хөрөнгийг 7.8 тэрбум төгрөг байхаар баталсан байна.

Тэтгэврийн нэрийн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д “нэрийн дансыг Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжид заасан нөхцөл, журмын дагуу тэтгэврийн даатгалд хамрагдсан, 1960 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр ба түүнээс хойш төрсөн Монгол Улсын иргэн, тус улсад байнга оршин суугаа гадаадын иргэн болон харьяалалгүй хүнд нээнэ” гэж заасан байна.

Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны 2013 оны гүйцэтгэл аудитын явцад нэгтгэгдэж гараагүй байгаа бөгөөд 2012 оны байдлаар 1,107.1 мянган даатгуулагч иргэн бүртгэгдэж, нэрийн дансны эхний үлдэгдэл 5,302,739.2 сая төгрөг, 2012 онд төлсөн шимтгэл 399,233.6 сая төгрөг, шимтгэлийн хүүг 20.6 хувиар тооцон 1,174,606.4 сая төгрөгийг тус тус бүртгэж, ТДШНД-ийг 6,876,579.2 сая төгрөгийн үлдэгдэлтэйгээр хийсвэр тооцоолол хийгдсэн байна.

**БҮЛЭГ 1. ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГИЙН
БҮРДҮҮЛЭЛТ, ЗАРЦУУЛАЛТ**

**1.1. ЭМДСЗ хуульд заасны дагуу ажиллахгүй, хууль тогтоомжийн зарим
заалт хэрэгжихгүй байна**

ИЭМДТ хуулийн 5.1-д "...Эрүүл мэндийн даатгалын орон тооны бус салбар зөвлөл /цаашид "даатгалын зөвлөл" гэх/-ийг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дэргэд ажиллуулна...", 5.5-д "...Даатгалын зөвлөл нь аймаг, нийслэлд орон тооны бус салбар зөвлөлтэй байна..." гэж заасан байна.

"Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дэргэдэх эрүүл мэндийн даатгалын салбар зөвлөлийн ажиллах журам"-ыг НДҮЗ-ийн 2002 оны 9 дүгээр тогтоолоор баталсан байна.

НДҮЗ-ийн 2013 оны 1 дүгээр сарын 7-ны өдрийн 1 дүгээр тогтоолоор "Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дэргэдэх эрүүл мэндийн даатгалын салбар зөвлөлийн ажиллах журам"-ыг хүчингүй болгож, тус журмыг шинэчлэн боловсруулж, батлуулахыг ЭМДСЗ-ийн нарийн бичгийн дарга болон ЭМДГ-ын дарга нарт үүрэг болгожээ.

Дээрх журмыг шинэчлэн боловсруулж батлуулаагүйгээс орон нутгийн ЭМДСЗ 2013 онд үйл ажиллагаа явуулаагүй нь ИЭМДТ хуулийн 5 дугаар зүйлийн 5.2.1¹, 5.2.3² дахь заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Эрүүл мэндийн даатгалын салбар зөвлөлийн ажиллах журам хүчингүй болсны улмаас орон нутагт ЭМД-ын орон тооны бус салбар зөвлөл үйл ажиллагаагаа явуулаагүй байхад 8 аймгийн ЭМД-ын салбар зөвлөлийн дарга, гишүүдэд ажлын оролцоог харгалзахгүйгээр урамшуулал олгосон нь ИЭМДТ хуулийн 5 дугаар зүйлийн 5.4³ дэх заалттай нийцэхгүй байна. Тухайлбал:

- Дундговь аймагт 1,320.0, Баянхонгор аймагт 1,516.3, Дархан-Уул аймагт 680.4, Дорнод аймагт 1,516.3, Сүхбаатар аймагт 1,516.3, Ховд аймагт 500.0, Өвөрхангай аймагт 1,515.2, Өмнөговь аймагт 319.7 мянга, нийт 8,884.2 мянган төгрөгийн урамшуулал олгосон;

1.2. Эрүүл мэндийн даатгалд иргэдийг бүрэн хамруулаагүйгээс сангийн орлого нэмж бүрдэх боломжийг алдсан байна

Монгол Улсын иргэн бүр эрүүл мэндийн даатгалд заавал хамрагдах үүрэгтэй бөгөөд гадаадын иргэн, харьялалгүй хүн сайн дурын үндсэн дээр даатгуулж болохоор хуульчилсан байна.

Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого нь ажил олгогч, даатгуулагчийн төлсөн шимтгэл, төр шимтгэлийг нь хариуцдаг иргэдийн шимтгэл, малчин, тодорхой хөдөлмөр эрхлээгүй иргэний өөрөө төлсөн шимтгэл, хугацаандаа төлөгдөөгүй шимтгэлд ногдуулсан алданги, сангийн чөлөөт үлдэгдлийг банкинд байрлуулсны хүүгийн орлогоос тус тус бүрдэж байна.

2013 онд ЭМД-ын санд 203,954.2 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, батлагдсан төлөвлөгөөг 1,624.1 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна. /Хавсралт 1-ээс үзнэ үү./


¹ Эрүүл мэндийн даатгалын сангийн ашиглалт, зарцуулалтад хяналт тавих

² Эрүүл мэндийн даатгалын тухай хууль тогтоомж, даатгалын үйл ажиллагаатай холбогдсон асуудлаар санал боловсруулж, холбогдох байгууллагар шийдвэрлүүлэх

³ Даатгалын зөвлөлийн дарга, гишүүдэд ажлын оролцоог харгалзан урамшуулал олгож болно.

Сангийн орлогын эх үүсвэрийг графикаар харуулбал:

/сая.төгрөг/



Иргэдийг даатгалд бүрэн хамруулаагүй байна

Аудитын явцад НДЕГ-ын ЭМДГ-ын 2013 оны тайланг судлахад тус газар ЭМДС-ийн орлогыг төлөвлөхдөө улсын хэмжээний иргэний бүртгэлийн нэгдсэн бодит тоо мэдээнд үндэслэн төлөвлөдөггүй, ЭМД-д нийтийг бүрэн хамруулах, сурталчилах, мэдээллээр хангах үүрэгт ажлаа хангалтгүй зохион байгуулсан, иргэд эрүүл мэндийн даатгалд заавал хамрагдах үүргээ биелүүлэхгүй байгаа нь сангийн орлогын бүрдүүлэлтэд сөргөөр нөлөөлж байна.

Мөн ИЭМД-ын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2.3⁴-т заасан үүргээ баг, хорооны Засаг дарга бүрэн хэрэгжүүлэхгүй байгаагаас эрүүл мэндийн даатгалд даатгагдах иргэдийн хамралтын хувь хангалтгүй байна.

ҮСХ-ны 2013 оны мэдээгээр улсын хэмжээнд нийт 203.6 мянган малчин, 190.4 мянган оюутан суралцагч, 276.9 мянган ажил хөдөлмөр эрхлээгүй иргэн байгаагаас 118.6 мянган малчин, 171.9 мянган оюутан суралцагч, 227.6 мянган ажил хөдөлмөр эрхлээгүй иргэнийг эрүүл мэндийн даатгалд хамруулсан байна.

Нийт даатгуулагчийн төлсөн шимтгэлийг ЭМДС-д бүрэн төвлөрүүлсэн ч улсын хэмжээнд ЭМД-д хамрагдалт 97.7 хувьтай байгаа бөгөөд үүний 97.3 хувь нь заавал даатгалд хамрагдах даатгуулагч, 0.3 хувь нь сайн дурын даатгуулагч байна.

Даатгалд хамрагдаагүй даатгуулагчийн дийлэнх хувийг ЭМД-ын шимтгэлээ өөрөө хариуцан төлдөг малчин, ажил хөдөлмөр эрхлээгүй иргэд, оюутан суралцагч эзэлж байна. Тухайлбал:

- Нийслэлийн статистикийн газрын 2013 оны тоо мэдээгээр 2013-2014 оны хичээлийн жилд МСҮТ-д 18182 суралцагч суралцсан байхад 5400 суралцагчийг ЭМД-д хамруулж 12782 суралцагчийг ЭМД-д хамруулаагүйгээс ойролцоогоор 102.8 сая, 2013 оны тооллогоо нийт 2798 малчин тоологдсон байхад ЭМД-д 1151 малчин хамрагдаж 1647 малчин даатгалд хамрагдаагүйгээс 13.4 сая, нийт 116.1 сая төгрөгийн орлогыг ЭМДС-д төвлөрүүлэх боломжийг алдсан;
- Дундговь аймгийн хэмжээнд нийт 10938 малчин байгаагаас тэтгэврийн насны 1284 иргэнийг хасаад нийт 9654 малчин иргэн даатгалд хамрагдахаас 5563 иргэн хамрагдаж 4091 малчин иргэнийг хамруулаагүйгээс ойролцоогоор ЭМДС-д 32.9 сая төгрөг төвлөрүүлэх боломжийг алдсан;

⁴ "Энэ хуулийн 6.1.8 /малчин/, 6.1.11 /энэ зүйлийн 6.1.1-6.1.10-т зааснаас бусад иргэн/-д заасан даатгуулагчийн даатгалын шимтгэлийг баг, хорооны Засаг дарга хариуцаж, даатгагчтай байгуулсан тэрээний дагуу"

- Сэлэнгэ аймгийн хэмжээнд заавал даатгалд хамрагдах нийт 105234 даатгуулагч байгаагаас 96458 иргэн даатгалд хамрагдаж 8776 иргэнийг хамруулаагүйгээс ЭМДС-д ойролцоогоор 70.6 сая төгрөг төвлөрүүлэх боломжийг алдсан;
- Баян-Өлгий аймгийн хэмжээнд заавал даатгалд хамрагдах нийт 88952 даатгуулагч байгаагаас 79476 иргэн даатгалд хамрагдаж 9476 иргэнийг хамруулаагүйгээс ЭМДС-д ойролцоогоор 76.2 сая төгрөг төвлөрүүлэх боломжийг алдсан;
- Увс аймгийн хэмжээнд заавал даатгалд хамрагдах нийт 74096 даатгуулагч байгаагаас 69831 иргэн даатгалд хамрагдаж 9476 иргэнийг хамруулаагүйгээс ЭМДС-д ойролцоогоор 34.3 сая төгрөг төвлөрүүлэх боломжийг алдсан;
- Баянхонгор аймгийн МСҮТ-ийн өдрийн ангид 2013-2014 оны хичээлийн жилд 1194 суралцагч суралцаж байгаагаас 1039 суралцагчийг ЭМД-д хамруулж, 298 суралцагчийг ЭМД-д хамруулаагүйгээгээс ойролцоогоор 2.4 сая төгрөгийн шимтгэлийн орлогыг төвлөрүүлээгүй;
- Говь-Алтай аймагт ЭМДС-д заавал даатгуулах 62264 иргэний 2,386.7 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлэхээс, гүйцэтгэлээр 2,175.1 мянган төгрөгийг төвлөрүүлж, зөрүү 211.6 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлээгүй;

Зарим ажил олгогч “Нийгмийн даатгалын тухай” хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй байна

ЭМДС-д аж ахуйн нэгж байгууллага, төсөвт газраас төлөх шимтгэлийг 2013 онд 181,701.3 сая төгрөгөөр төлөвлөснөөс 169,257.2 сая төгрөг төвлөрч 12,444.1 сая төгрөгөөр буюу 6.8 хувиар тасарсан байна.

Аж ахуйн нэгж байгууллага, төсөвт газраас төлөх орлогын төлөвлөгөө тасархад ЭМДС-ийн нийт орлогын төлөвлөгөөг УИХ-аас баталсан төсвийн тодотголын дагуу НДҮЗ-ийн 2013 оны 31 дүгээр тогтоолоор 19,234.8 сая төгрөгөөр өсгөн баталсан, аж ахуйн нэгж байгууллага төлөх шимтгэлээ хугацаанд нь төлөөгүйгээс авлага үүсгэсэнтэй холбоотой байна.

Мөн ААН байгууллагууд Татварын байгууллагад цалингийн сан үүсгэж, ашгийн татвар төлсөн ч НДТХ-ийн 4 дүгээр зүйлийн 4.2-т⁵ заасныг зөрчин нийгмийн даатгалын албанд бүртгүүлээгүй, ЭМД-ын шимтгэл төлөөгүй зөрчил гаргасан байна. Тухайлбал:

- Нийслэлд нийгмийн даатгалын албанд бүртгэгдээгүй, НДШ төлөөгүй 1292 аж ахуйн нэгжээс 774,446.6 мянган төгрөгийг ЭМДС-д нэмж төвлөрүүлэх боломжийг алдсан;
- Дундговь аймагт Татварын албанд тайлан ирүүлсэн аж ахуйн нэгжүүдээс 74 ААН-ийг ЭМД-д хамруулаагүй;
- Заахан аймагт Татварын албанд тайлан ирүүлсэн аж ахуйн нэгжүүдээс 480 ААН-ийг ЭМД-д хамруулаагүй;

Төрөөс даатгалыг нь хариуцах иргэдийн эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг Хүний хөгжил сангаас бүрэн төвлөрүүлсэн байна

ИЭМДТХ-ийн 8 дугаар зүйлийн 8.2.4-т зааснаар уг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3⁶, 6.1.4⁷, 6.1.5⁸, 6.1.7⁹-д заасан даатгуулагчийн ЭМД-ын шимтгэлийг Хүний хөгжил сангийн төсвөөс төр хариуцан төлөхөөр хуульчилсан байна.

⁵Нийгмийн даатгалын тухай хуулийн 4.2 “Нийгмийн даатгалд өмчийн бүх хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллага, төрийн бус, шашны болон бусад байгуулага, иргэнтэй хөдөлмөрийн гэрзэээр, эсхүл Иргэний хуулийн 343, 359 дүгээр зүйлд зааснаар иргэнтэй байгуулсан гэрээний дагуу ажиллаж байгаа Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн албан журмаар даатгуулна”

⁶16 /өрөнхий боловсролын сургуульд суралцаж байгаа бол 18 хүртэлх насны хүүхэд”-т/

⁷их, дээд сургууль, коллежийн өдрийн ангийн суралцагч”-т

⁸тэтгэврээс өөр мөнгөн орлогогүй иргэн”-т, 6.1.6 “хүүхдээ 2 /ихэр бол 3 / нас хүртэл нь өсгөн бойжуулж байгаа эх /эцэг”-т

⁹хугацаат цэргийн жинхэнэ албан хаагч”-т, 6.1.9 “Нийгмийн халамжийн тухай хуулийн 12 дугаар зүйлд заасаниргэн”

Нийгмийн даатгалын тухай хууль, тухайн жилийн Төсвийн тухай хууль, Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуульд зааснаар төрөөс хариуцах иргэдийн төлөх шимтгэлийг Засгийн газрын 2009 оны 374 дүгээр тогтоолын дагуу 2010 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн Хүний хөгжлийн сангаас сард 670 төгрөг, жилд 8040 төгрөгөөр тооцож эрүүл мэндийн даатгалын санд сар бүр шилжүүлэн төлжээ.

Нийгмийн даатгалын сангийн 2013 оны төсөвт Хүний хөгжил сангаас төлөх иргэний эрүүл мэндийн даатгалын шимтгэлд 1,658,254 иргэний 12,151.5 сая төгрөг төвлөрүүлэхээр батлагдаж бүрэн төвлөрүүлсэн байна.

Төр шимтгэлийг нь хариуцдаг даатгуулагчийн тоо 2013 оны байдлаар нийт даатгуулагчийн 56.5 хувийг эзэлж байна.

ЭМД-ыг төрөөс хариуцах иргэдийн судалгааг орон нутгийн Нийгмийн даатгалын байгууллагуудаас гаргуулан авч үзэхэд иргэдийг бүрэн хамруулаагүй зөрчил гарсан байна. Тухайлбал:

- Ус аймгийн хэмжээнд ЭМД-ийг төрөөс хариуцах иргэдийн 30.1 хувийг,
- Сүхбаатар аймгийн хэмжээнд 43.9 хувийг,
- Говь-Алтай аймгийн хэмжээнд 36.2 хувийг,
- Баянхонгор аймгийн хэмжээнд 30.5 хувийг,
- Архангай аймгийн хэмжээнд 37.0 хувийг,
- Баян-Өлгий аймгийн хэмжээнд 36.7 хувийг тус тус даатгалд хамруулаагүй байна.

Нийгмийн даатгалын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1¹⁰, 20.1.2¹¹, 20.1.3¹²-т заасны дагуу шимтгэлийг хугацаанд нь төлөөгүй ААН, байгууллага, даатгуулагчаас 308.2 сая төгрөгийн алданги тооцож төвлөрүүлсэн ч дээрх хуулийн 16 дугаар зүйлийн 16.3¹³-т заасныг зөрчин шимтгэл төлөх хугацааг 60-с дээш хоногоор хэтрүүлсэн ААН-д алданги тооцоогүй тохиолдол гарсан байна. Тухайлбал:

-Нийслэлд 2013 онд 1381 ААНБ-аас ЭМДС-д орох 92.3 сая төгрөгийн авлагад тодорхой ажиллагаа хийгдээгүй, 30.9 сая төгрөгийн алдангийг тооцоогүй;

-Говь-Алтай аймагт 2013 оны эцсийн үлдээгдэл 9.9 сая төгрөгийн авлагад алданги тооцоогүй;

-Дорноговь аймаг 103.4 сая төгрөгийн авлагад алданги тооцоогүй;

ЭМДС-д 2013 онд 310.4 сая төгрөгийн хүүгийн орлогыг төвлөрүүлсэн байна

Нийгмийн даатгалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3¹⁴-т заасны дагуу аймаг, нийслэл, сум, дүүргийн нийгмийн даатгалын газар, хэлтсүүд 2013 онд ХААН, Капитал, Улаанбаатар, Төрийн банк зэрэг арилжааны 9 банктай "Хамтран ажиллах гэрээ" байгуулан ажилласан байна.

¹⁰Ажил олгогч шимтгэл ногдох хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлогыг нуусан буюу хэмжээг нь санаатайгаар бууруулсан бол нуусан буюу бууруулсан орлогод ногдох шимтгэлийг нөхөн төлүүлж, мөн орлоготой тэнцэх хэмжээний алданги ногдуулна. Энэхүү алдангийн хэмжээ нь төлбөл зохих шимтгэлийн 50 хувиас хэтрэхгүй байна

¹¹дтуу төлөгдсөн буюу хугацаандгаа төлөгдөөгүй шимтгэлийг нөхөн төлүүлж, шимтгэлийн дүнгээс хугацаа хэтрүүлсэн хоног тутамд 0,3 хувийн алданги ногдуулна. Энэхүү алдангийн хэмжээ нь төлбөл зохих шимтгэлийн 50 хувиас хэтрэхгүй байна


¹²тооцооны алдаа гаргаснаас шимтгэлийг дтуу төлсөн бол дтуу төлсөн шимтгэлийг нөхөн төлүүлж, уг шимтгэлийн дүнгээс тооцооны алдаа гарснаас хойших хугацааны хоног тутамд 0,1 хувийн алданги ногдуулах боловч алдангийн нийт хэмжээ дтуу төлсөн шимтгэлийн 30 хувиас хэтэрч болохгүй"

¹³16. 3. Хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан даатгуулагчийн болон ажил олгогчийн тухайн сарын төлөх шимтгэлийг дараа сарын 5-ны дотор төлсөн байна.

¹⁴"Хуримтлалын сангийн хөрөнгийг ЗГ-ын бонд, Монгол банкнаас гаргасан үнэт цаас худалдан авах, арилжааны банкинд байршуулах замаар нэмэгдүүлж болно"

ЭМДС-ийн харилцах дансны үлдэгдлийг графикаар үзүүүлбэл:

/сая төгрөг/



ЭМДС-ийн харилцах дансанд байршиж байгаа нийт харилцах, хадгаламжийн үлдэгдэл 250.2 тэрбум төгрөгийн 22.4 хувь буюу 56.0 тэрбум төгрөгийг Төрийн санд байршуулсан нь ойролцоогоор 3.1 тэрбум төгрөгийн хүүгийн орлого олох боломжийг алдсан байна.

2013 онд ЭМДС-ийн өдөр тутмын чөлөөт үлдэгдэлд жилийн 5.5 хувийн хүү тооцож, хадгаламжийн хүүгийн орлогоор 7,922.3 сая, бондын хүүгийн орлогоор 3,924.0 сая, харилцахын хүүгийн орлогоор 5,749.5 сая нийт 17,595.8 сая төгрөгийн хүүгийн орлого бүрдүүлсэн ч хүүг дутуу тооцсон зөрчил илэрсэн байна. Тухайлбал:

- СБД-ийн НДХэлтэс нь ХААН банк, Капитал банктай байгуулсан хамтран ажиллах гэрээний 2.4¹⁵, 4.1¹⁶, 7.1¹⁷ заалтыг бүрэн хэрэгжүүлээгүйгээс ХААН банкин дахь 5009209225 тоот дансны, Капитал банкин дахь 2012000058 тоот дансны ЭМДС-ийн өдөр тутмын чөлөөт үлдэгдэлд жилийн дүнгээр 0.8 сая төгрөгийн хүүг дутуу тооцуулсан;

- Ус аймгийн ЭМДС 2013 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 237.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй бөгөөд үүний 90.8 хувь буюу 215.7 сая, Баян-Өлгий аймгийн ЭМДС нь 214.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй бөгөөд үүний 87.8 хувь буюу 188.3 сая төгрөг нь төрийн сан банкинд байршиж байгаа нь ЭМДС-д 22.2 сая төгрөгийн хүүгийн орлого олох боломжийг алдагдуулсан байна.

ЭМДС-ийн чөлөөт үлдэгдлийг арилжааны банкуудад байршуулахдаа тооцож буй хүүгийн хувь нь арилжааны банкны жилийн дундаж хүүгээс /Арилжааны банкны жилийн дундаж хүү 6-7.5 хувь/ бага, чөлөөт үлдэгдлийн 22.4 хувь нь Төрийн санд байршиж байгаа зэрэг нь сангийн чөлөөт үлдэгдлийг байршуулах менежментийг зөв зохион байгуулахгүй байгааг харуулж байна.


¹⁵... банк нь харилцах дансны өдөр тутмын үлдэгдэлд жилийн 5.5 хувийн хүүг өдөр тутам хуримтлуулан тооцож, сар бүрийн эцэст хүүгийн орлогыг шилжүүлж..."

¹⁶...НДХ нь дансны гүйлгээ, үлдэгдэлээ сар, улирал, жилийн эцэст тооцоо нийлж, акт үйлдэж баталгаажуулах ба энэ хугацаанд илэрсэн зөрчил дутагдлыг арилгаж ажиллана..",

¹⁷...2013 оны 2 дугаар сарын 14-ний өдрөөс эхлэн 1 жилийн хугацаагаар дагаж мөрднө..."

1.3. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний зардлыг журам зөрчин санхүүжүүлсэн, ЭМДС-ийн цахим мэдээллийн баазад даатгуулагчийн мэдээлэл зөрүүтэй бүртгэгдсэн байна

Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн дагуу эрүүл мэндийн даатгалын сангаас дараах зардлуудыг санхүүжүүлдэг байна.



НДҮЗ-ийн 2013 оны “Тодотгосон төсвийн хуваарь батлах тухай” 31 дүгээр тогтоолоор ЭМДС-ийн 2013 оны нийт зардлыг 131.4 тэрбум төгрөгөөр, үүнээс үйл ажиллагааны зардалд 3.7 тэрбум, хөрөнгө оруулалтад 1.1 тэрбум, нийт 4.8 тэрбум төгрөг буюу сангийн нийт зардлын 3.7 хувийг зарцуулахаар баталж зарцуулсан байна.

Эрүүл мэндийн даатгалын сангаас 2013 онд давхардсан тоогоор 3,843.2 мянган даатгуулагчийн тусламж, үйлчилгээний зардалд нийт 120.7 тэрбум төгрөгийг батлагдсан төсвийн хүрээнд зарцуулсан байна.

ЭМДС-ийн хөрөнгийн зарцуулалтыг хүснэгтээр харуулбал:

Тусламж үйлчилгээ	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд хамрагдсан				/мянган хүн, тэрбум төгрөгөөр/ ЭМДС-ийн зарцуулалт			
	Хүний тоо		Өсөлт, бууралт		2013 он		Өсөлт, бууралт	
	2012 он	2013 он	Дүн	Хувь	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Хувь
Эмнэлэг, Сувилал	3364.7	2988.7	-376.0	11.2	114.3	111.0	3.3	2.9
Эмийн үнийн хөнгөлөлт	706.9	854.5	+147.6	20.9	12.2	9.7	2.4	19.8
ЭМДС-ийн үйл ажиллагааны зардал					3.7	3.7		
Хөрөнгө оруулалтад					1.1	1.1		
Бусад зардалд					0.1	0.1		
НИЙТ ДҮН	4126.4	3843.2	-283.2	6.9	131.4	125.6	5.7	4.5

Эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдаж тусламж, хөнгөлөлт авсан хүний тоо урьд оноос 283.2 мянган хүнээр, олгосон хөрөнгө 5.7 тэрбум төгрөг буюу 4.5 хувиар буурсан байна.

Эмнэлгийн тусламж үйлчилгээ, эмийн үнийн хөнгөлөлт 5.7 тэрбум төгрөгөөр буурсан шалтгааныг тодорхойлбол:

- Төсөвт нэмэлт тодотгол оруулах саналыг 2013 оны эхэнд өгсөн боловч 11 дүгээр сарын 25-нд УИХ-аас тодотгол хийснээр эрүүл мэндийн байгууллагууд

ялангуяа эмийн сангудад шинэ төсвийг баримтлан даатгуулагчдад үйлчлэх цаг хугацаа хангалтгүй байсан;

- Сум дундын эмнэлгүүд нарийн мэргэжлийн эмч, мэс заслын эмч байхгүй, эсвэл тэдгээр нь тогтвортой ажиллагаагүй, мэргэжлийн боловсон хүчний дутагталтай байдлаас шалтгаалж үйл ажиллагаа доголдсон;
- Рашаан сувилалуудын ачаалал урин дулааны улиралд ихэсдэгээс ЭМС-ийн баталсан орны тооноос илүү хүнд үйлчилдэг ч эрүүл мэндийн тусламж үйлчилгээний санхүүжилт нь сар бүр тэнцүү хэмжээгээр батлагдагаас ачаалал ихтэй сарын санхүүжилтээ бүрэн авч чадаггүй, ачаалал багатай сард батлагдсан санхүүжилт нь зарцуулагдахгүй үлддэг;
- Хувийн эмнэлгүүдийн магадлан итгэмжлэлийн эрхийн хугацаа нь дуусгавар болсон зэргээс шалтгаалсан байна.

2013 оны байдлаар нийт даатгуулагчдын 56.5 хувь нь сард 670 төгрөг, жилд 8040 төгрөг буюу албан салбарт ажиллагсаас бараг 20 дахин бага шимтгэл төлж байгаа нь хэт ялгаатай байна. Өөрөөр хэлбэл албан салбарын даатгуулагч өндөр шимтгэл төлдөг боловч эрүүл мэндийн тусламж үйлчилгээг бага хүртэж, бусад бүлгүүдийн даатгагчдын төлж буй шимтгэл бага боловч эрүүл мэндийн тусламж үйлчилгээг илүү авч байна. Энэ нь хэдийгээр харилцан дэмжих эв хамтын зарчим боловч бүлгүүдийн орлого зарлагын харьцааг бага боловч уялдуулах шаардлага байгааг харуулж байна.

Эрүүл мэндийн даатгалын сангийн үйл ажиллагааны болон хөрөнгө оруулалтын зардлын талаар:

Нийгмийн даатгалын сангийн 2013 оны Төсвийн тухай хуулиар НДС-ийн үйл ажиллагааны урсгал зардлыг 18.3 тэрбум, хөрөнгийн зардлыг 5.3 тэрбум төгрөгөөр баталсныг НДҮЗ-ийн 2013 оны 31 дүгээр тогтоолоор ЭМДС-аас зарцуулагдах үйл ажиллагааны зардлыг 3.7 тэрбум, хөрөнгө оруулалтын зардлыг 1.1 тэрбум төгрөгөөр баталсан байна.

ЭМДС-ийн үйл ажиллагааны зардлын өсөлтийг харуулбал:

/сая төгрөгөөр/

Зардлын зүйл	Зарцуулалтын гүйцэтгэл			2014 оны батлагдсан төсөв
	2011 он	2012 он	2013 он	
Үйл ажиллагааны зардал	2,157.3	2,670.9	3,693.7	3,977.7
Хөрөнгө оруулалтын зардал	464.7	300.2	1,082.0	5,085.9

Үйл ажиллагааны зардал 2013 онд өмнөх оноос 38.3 хувиар буюу 1.0 тэрбум төгрөгөөр, хөрөнгө оруулалтын зардал 260.4 хувиар буюу 781.8 сая төгрөгөөр өссөн, 2014 онд үйл ажиллагааны зардлыг 7.7 хувь буюу 284.0 сая төгрөгөөр, хөрөнгө оруулалтын зардлыг 370.0 хувиар буюу 4,003.9 сая төгрөгөөр нэмэгдүүлэхээр баталсан байна.

Нийгмийн даатгалын сангийн 2013 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, гүйцэтгэлийг хүснэгтээр үзүүлбэл:

/сая төгрөгөөр/

Зардал	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	I+/өсөлт, I-/бууралт	
			Тоогоор	Хувиар
Барилга байгууламж, их засвар	4213,9	4101,1	-112,9	-2,7
Тоног төхөөрөмж	521,8	515,7	-6,1	-1,1
Тээврийн хэрэгсэл	340,0	332,8	-7,2	-2,2
Тавилга, эд хогшил	307,2	306,3	-0,9	-0,3
НИЙТ ДҮН	5383,0	5255,8	-127,2	-2,3


ЭМДС-ийн хөрөнгө буюу даатгуулагчдын төлсөн шимтгэлээс жил бүр нэмэгдүүлэн баталж, зарцуулж байгаа нийгмийн даатгалын салбарын хөрөнгө оруулалтын зардлыг бууруулах шаардлагатай байна.

Өнөөдрийн байдлаар эмнэлгийн зардлыг ЭМДС, улсын төсөв, үндсэн үйл ажиллагааны орлого гэсэн 3 эх үүсвэрээс санхүүжүүлж байгаа боловч ямар тусlamж үйлчилгээ, ямар зардлыг аль эх үүсвэрээс санхүүжүүлэхийг тодорхой заасан эрх зүйн орчин байхгүй учраас зарцуулалтыг зориулалтаар нь зарцуулсан эсэхийг хянах боломжгүйгээс ЭМДС-ийн санхүүжилт нь эмнэлгийн тусlamж үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх хөшүүрэг болж чадахгүй байна.

Нийслэлд үйл ажиллагаа явуулж байгаа хоёр, гуравдугаар шатлалын эмнэлгүүдээс түүвэрлэн авч батлагдсан төсөвт зардлын эх үүсвэрийн бүтцийг судалж үзэхэд гуравдугаар шатлалын буюу клиникийн эмнэлгүүдийн нийт санхүүжилтийн 10.4-12.7 хувийг үндсэн үйл ажиллагааны орлогоос, 40.6-41.9 хувийг улсын төсвөөс, 45.4-49.0 хувийг ЭМДС-ийн санхүүжилтээр, хоёрдугаар шатлалын буюу дүүргийн эмнэлгүүдийн нийт санхүүжилтийн 1.3-2.3 хувийг үндсэн үйл ажиллагааны орлогоос, 3.4-34.3 хувийг улсын төсвөөс, 63.4-95.3 хувийг ЭМДС-ийн санхүүжилтээр санхүүжүүлж байна.

2,3 дугаар шатлалын эмнэлгүүдийн санхүүжилтийн эх үүсвэр /хувиар/

- Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих
- Төсвөөс санхүүжих
- ЭМД-аас санхүүжих



Гуравдугаар шатлалын буюу клиникийн эмнэлгүүдийн тусlamж үйлчилгээний хувьсах зардлын 37.0 орчим хувь нь датгуулагчийн эм тария, хоолны зардалд, 63.0 орчим хувь нь эмнэлгийн үйл ажиллагааны зардалд, хоёрдугаар шатлалын буюу дүүргийн эмнэлгүүдийн тусlamж үйлчилгээний хувьсах зардлын 20.0 орчим хувь нь датгуулагчийн эм тария, хоолны зардалд, 80.0 орчим хувь нь эмнэлгийн үйл ажиллагааны зардалд зарцуулагдаж байна.

Хоёр, гуравдугаар шатлалын эмнэлгийн зардлын хуваарилалтын дундаж хувийг хүснэгтээр үзүүлбэл: /нийт зардалд зэлэх хувиар/

Үзүүлэлт	Гуравдугаар шатлалын эмнэлэг			Хоёрдугаар шатлалын эмнэлэг			
	I эмнэлэг	II эмнэлэг	Дундаж хувь	Худ НЭ	Худ ЭМН	ЧД ЭМН	Дундаж хувь
Үндсэн цалин	38.3	51.2	44.8	60.1	66.6	63.0	63.2
НДШ	4.2	5.6	4.9	6.6	7.3	6.9	6.9
Бичиг хэрэг	0.2	0.2	0.2	0.4	0.3	0.3	0.3
Гэрэл цахилгаан	1.3	1.3	1.3	2.0	0.8	0.9	1.2
Халаалт	0.8	2.4	1.6	3.0	2.2	2.0	2.4
Тээвэр шатахуун	0.09	0.9	0.5	0.2	0.9	1.0	0.7
Шуудан холбоо	0.08	0.2	0.1	0.1	0.1	0.1	0.1
Цэвэр бохир ус	0.4	1.3	0.8	5.3	0.6	0.9	2.3
Хөдөлмөр хамгаалал /НХЗЭ, БҮТЭЗ/	1	1.3	0.9	0.3	0.2	0.5	0.3

Хоолны зардал	3.7	2.8	3.2	8.6	3.1	5.9	5.8
Эмийн зардал	46.2	22.6	34.4	12.4	15.1	15.8	14.5
Ургал засвар	0.2	0.6	0.4	0.5	0.2	0.1	0.4
Бусад зардал	3.5	9.7	6.6	0.5	2.6	2.6	1.9

Хүснэгтээс харахад цаашид даатгуулагчийн эмчилгээ, оношилгооны чанарыг сайжруулах үүднээс эм тарианы зардлын эзлэх хувь хэмжээг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Урамшууллын зардлын талаар

НДТХ-ийн 7 дугаар зүйлийн 7.8¹⁸ дахь заалтын дагуу үзлэгт хамрагдахын тулд шаардлага хангасан иргэн өөрийн хүсэлтийг тавих ёстой байна.

НДЕГ-ын тайланд дурьдсанаар дараалсан 3 жилийн хугацаанд эмнэлгийн тусламж, үйлчилгээ аваагүй даатгуулагчид жилд 22000 төгрөгийн эрүүл мэндийн үзлэг оношилгоо хийлгэх урамшууллаар улсын хэмжээнд 2011 онд 1670 хүнд 36.7 сая төгрөгийн, 2013 онд 262 хүнд 6.4 сая төгрөгийн эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлсэн нь орон даяар энэ урамшуулалыг нийт ард иргэдэд сурталчилах ажил хангалтгүй байгааг харуулж байгаа бөгөөд иргэд урамшууллаар эмнэлгийн тусламж үйлчилгээг хүртэж чадаагүй байна.

2012 онд ЭМДС-аас дээрх урамшууллын зардал гараагүй байна.

Даатгуулагчад үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний зардлыг олгоходоо зарим хууль эрх зүйн актын холбогдох заалтуудыг бүрэн хэрэгжүүлээгүй байна

ИЭМД-ын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4 дэх заалтыг үндэслэн гаргасан ЭМС-ын 2009 оны 180 тоот тушаалаар "ЭМД-ын сангаас санхүүжих тусламж үйлчилгээний төлбөрийн арга, зардлын хэмжээг тооцох журам"-ын 11-д "ИЭМД-ын хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д заасны дагуу хувьсах зардлын хэмжээг тогтоохдоо сүүлийн 3 жилийн өвчлөлтийн статистик үзүүлэлт, тусламж үйлчилгээний эрэлт хэрэгцээ, өртгийн тооцоо, инфляци, хэрэглээний үнийн индекс, даатгалын нөөцийн чадавхийг тооцон жил бүр шинэчлэн тогтооно" гэж заасан байхад 2013 онд даатгуулагчид үзүүлэх тусламж үйлчилгээний хувьсах зардлын хэмжээг ЭМС, СС, НХХС шинэчлэн тогтоогоогүй байна.

Зарим аймаг, дүүргийн НДХ 2013 онд ЭМДС-ийн орлого бүрдүүлэх, эрүүл мэндийн даатгалын тусламж үйлчилгээ үзүүлэх байгууллагатай гэрээ байгуулах, гэрээний биелэлтэд хяналт тавих, даатгуулагчид үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарт хяналт тавих, санхүүжүүлэх зэрэг ИЭМДТ хуулийн 5 дугаар зүйлийн 5¹.1.3¹⁹, 5¹.1.4²⁰, 5¹.1.5²¹-т заасан чиг үүргээ бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

НДЕГ нь 2013 онд нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулсан 217 эрүүл мэндийн байгууллагатай даатгалын гэрээ байгуулан 68.0 тэрбум төгрөгийн тусламж, үйлчилгээний зардлыг батлагдсан төсвийн хүрээнд санхүүжүүлжээ.

Үүнээс 24.0 тэрбум төгрөгийн санхүүжилтийг дээрх даатгалын гэрээний бүрэлдэхүүн хэсгийг бүрэн хангагүй төрийн өмчийн 14 эмнэлэг, хувийн хэвшлийн 29

¹⁸ "Дараалсан гурван жилийн хугацаанд эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээ аваагүй даатгуулагчийг нэг удаа эрүүл мэндийн бүрэн үзлэгт хамраулж урамшуулах бөгөөд журмыг нь Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл батална"

¹⁹ эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагатай даатгалын гэрээ байгуулах, гэрээний биелэлтэд хяналт тавьж, дүгнэх; өвчин, эмзгийн оношлогоо, эмчилгээний удирдамжийн дагуу даатгуулагчид үзүүлэх эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээний чанарт хяналт тавих;

²⁰ эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх;

²¹ эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх;

²² эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх;

²³ эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх;

²⁴ эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх;

²⁵ эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх;

²⁶ эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх;

²⁷ эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх;

²⁸ эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх;

²⁹ эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх;

³⁰ эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх;

³¹ эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх;

³² эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх;

³³ эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх;

³⁴ эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх;

³⁵ эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх;

³⁶ эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх;

³⁷ эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх;

³⁸ эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх;

³⁹ эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх;

⁴⁰ эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх;

⁴¹ эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх;

⁴² эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх;

⁴³ эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх;

⁴⁴ эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх;

⁴⁵ эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх;

⁴⁶ эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх;

⁴⁷ эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх;

⁴⁸ эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх;

⁴⁹ эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх;

⁵⁰ эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх;

⁵¹ эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх;

⁵² эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх;

⁵³ эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх;

⁵⁴ эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх;

⁵⁵ эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх;

⁵⁶ эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх;

⁵⁷ эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх;

⁵⁸ эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх;

⁵⁹ эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх;

⁶⁰ эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх;

⁶¹ эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх;

⁶² эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх;

⁶³ эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх;

⁶⁴ эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх;

⁶⁵ эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх;

⁶⁶ эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх;

⁶⁷ эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх;

⁶⁸ эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх;

⁶⁹ эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх;

⁷⁰ эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх;

⁷¹ эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх;

⁷² эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх;

⁷³ эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх;

⁷⁴ эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх;

⁷⁵ эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх;

⁷⁶ эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх;

⁷⁷ эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх;

⁷⁸ эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх;

⁷⁹ эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх;

⁸⁰ эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх;

⁸¹ эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх;

⁸² эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх;

⁸³ эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх;

⁸⁴ эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх;

⁸⁵ эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх;

⁸⁶ эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх;

⁸⁷ эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх;

⁸⁸ эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх;

⁸⁹ эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх;

⁹⁰ эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх;

⁹¹ эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх;

⁹² эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх;

⁹³ эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх;

⁹⁴ эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх;

⁹⁵ эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх;

⁹⁶ эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх;

⁹⁷ эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх;

⁹⁸ эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх;

⁹⁹ эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх;

¹⁰⁰ эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх;

¹⁰¹ эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх;

¹⁰² эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх;

¹⁰³ эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх;

¹⁰⁴ эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх;

¹⁰⁵ эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх;

¹⁰⁶ эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх;

¹⁰⁷ эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх;

¹⁰⁸ эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх;

¹⁰⁹ эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх;

¹¹⁰ эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх;

¹¹¹ эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх;

¹¹² эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх;

¹¹³ эрүүл

эмнэлэг, 5 рашаан сувилал, 79 эмийн санд олгосон зөрчлийг аудитын явцад бүрэн арилгуулсан болно.

Эрүүл мэндийн даатгалын сангаас эмнэлгийн тусламж үйлчилгээний зардал, эмийн үнийн хөнгөлөлт зэргийг хуулийн дагуу олгож байгаа боловч баримтын бүрдэл хангалтгүй, өвчний оношийн олон улсын ангилалыг хяналгүй, нэхэмжилсэн дүнгээр санхүүжилт олгосон, ЭМДС-ийн цахим мэдээллийн санд буруу мэдээлэл оруулдаг, ЭМД-ын гэрээг дүгнэхдээ даатгуулагчийн төлөөлөл оролцуулдаггүй, төсвийн тодотголын дагуу гэрээг шинэчилдэггүйгээс гэрээнд зааснаас илүү санхүүжилт олгодог, гэрээний бүрэлдэхүүн хэсэг бүрэн хангагдаагүй байхад санхүүжилт олгодог зэрэг зөрчил нийтлэг байна. Тухайлбал:

- БНД-ийн ЭМН 2013 онд 72247 даатгуулагчид үзүүлсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд 1,798.6 сая төгрөгийг ЭМДС-аас нэхэмжилсэнээс дүүргийн НДХ хянаж ЭМД-ын шимтгэл төлөөгүй 1715 даатгуулагчийн 53.4 сая төгрөгийг хасаж, 70532 даатгуулагчийн 1,745,2 сая төгрөгийг санхүүжүүлсэн;
- Налайх дүүргийн ЭМН нь 2013 онд 45434 даатгуулагчид үзүүлсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд 1,474.4 сая төгрөг нэхэмжилсэнээс дүүргийн НДХ 43509 даатгуулагчийн 1,399.6 сая буюу 94.9 хувийг санхүүжүүлэн, ЭМД-ын шимтгэл төлөөгүй 1925 даатгуулагчийн 74.7 сая төгрөг буюу нэхэмжилсэн дүнгийн 5.1 хувийг хасаж санхүүжүүлсэн;
- БНД-ийн НДХ нь ЭМДС-аас “Замбага” хувийн эмнэлэгт эрүүл мэндийн тусламж үйлчилгээний санхүүжилт олгоходоо 37 даатгуулагчийн өвчний оношийн олон улсын ангилалыг хянаагүйгээс 8 даатгуулагчийн оношийн хамаарах бүлгийг буруу буюу нэхэмжилсэн дүнгээр нь тооцож 0.2 сая төгрөгийн санхүүжилт илүү олгосон;
- БНД-ийн НДХ-ийн ЭМДС-ийн цахим мэдээллийн сан дахь мэдээлэлд 107 даатгуулагчийн 52.9 сая төгрөг, Налайх дүүрэгт 12 даатгуулагчийн 19.6 сая төгрөгийн зардал илүү бүртгэгдсэн;
- БНД, Налайх дүүргийн ЭМН, Эмийн сантай байгуулсан “Эрүүл мэндийн даатгалын гэрээ”-г дүгнэхдээ даатгуулагчийг төлөөлөх нэг ч гишүүн оролцуулахгүйгээр дүүргийн НДХ-ийн 2, ЭМН-ийн 2 хүний бүрэлдэхүүнтэйгээр гэрээг баталгаажуулсан;
- Төв, Хөөсгөл аймгуудын Эрүүл мэндийн байгууллагуудтай хийсэн гэрээг дүгнэхдээ иргэний төлөөлөл, өрхийн эмч нарын холбооны төлөөлөл оролцуулалгүйгээр ЭМД-ын хяналтын байцаагч эмч, ЭМД-ын зарлагын байцаагч нар дүгнэсэн;
- Хөөсгөл аймгийн хэмжээнд 22 эргэлтийн эмийн санд гэрээнд зааснаас 74.7 сая төгрөгөөр илүү санхүүжилт олгосон;

Дээрх зөрчлүүд нь ЭМС, СС, НХХС-ын 2011 оны “Даатгуулагчид үзүүлэх тусламж үйлчилгээний хувьсах зардлын даатгалын сангаас олгох хэмжээг тогтоох тухай” 438/273/A-146 тоот хамтарсан тушаалаар баталсан хэмжээ²², НДЕГ-ын даргын 2012 оны А/367 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “Нийгмийн даатгалын болон Эрүүл мэндийн байгууллага хооронд байгуулсан даатгалын гэрээг дүгнэх журам”-ын 2.2²³, 3.1.1²⁴, 3.1.2²⁵, 3.1.3²⁶-т заасан нөхцлүүд, ЭМДСЗ-ийн 2011 оны 3 дугаар тогтоолоор баталсан “Эрүүл мэндийн даатгалын сангаас зайлшгүй шаардлагатай эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх журам”-ыг тус тус зөрчсөн байна.

²²...Улсын болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын даатгуулагчид үзүүлэх тусламж, үйлчилгээний оношийн хамааралтай бүлгээр санхүүжүүлэх хувьсах зардлын даатгалын сангаас олгох хэмжээ...”

²³...НДБ нь эрүүл мэндийн байгуулагатай байгуулсан даатгалын гэрээг жилд 2 удаа буюу 7 дугаар сарын 20, дараа оны 1 дүгээр сарын 20-ны дотор тус дүгнэн...

²⁴Нийгмийн даатгалын байгууллагыг төлөөлж 3 хүртэлх хүн /нийгмийн даатгалын хэлтсийн дарга, эрүүл мэндийн даатгалын тасгийн дарга буюу хяналтын байцаагч эмчийн заавал оролцуулах/

²⁵Эрүүл мэндийн байгууллагыг төлөөлж 3 хүртэлх хүн /эмнэлгийн дарга, эмнэлгийн чанаарын албаны дарга, ЭМД хариуцсан эмч/

²⁶Даатгуулагчийг төлөөлж 3 хүн /ЭМДСЗ-ийн гишүүдээс/

НДХ-ийн даатгалын байцаагч эмч нар эмнэлгүүдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарт хяналт тавьж, мэргэжил арга зүйгээр хангасан гэх боловч чанарын хяналт тавьсан тэмдэглэл хөтөлж баримтжуулаагүй, гүйцэтгэлийн хяналт хийгээгүй зэргээр “Эрүүл мэндийн даатгалын гэрээ”-ний 3.3²⁷, 3.4²⁸, 3.5-т заасан үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Эмийн жоронд тавих хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүйгээс журам зөрчин зарим саруудад санхүүжилтийг хэтрүүлэн олгосон байна

2013 онд ЭМДС-аас эмийн үнийн хөнгөлөлтөд нийт 9,727.4 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Зарим аймгийн Эрүүл мэндийн газар, Нийгмийн даатгалын байгууллага “Эрүүл мэндийн даатгалын сангаас зайлшгүй шаардлагатай эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.4²⁹ дэх заалтыг хэрэгжүүлээгүй, эмийн сангуудад аттестатчлал явуулаагүй, НДҮЗ-ийн баталсан төсвийн хуваарийг баримтлаагүйгээс Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.4 дэх заалт, НББТ хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх заалт, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 1 дүгээр заалтуудыг зөрчсөн байна. Тухайлбал:

- Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газар эмийн сангуудад аттестатчлал явуулаагүй, Наян булаг ганга эмийн санд 2013 оны 5 дугаар сарын 1-31-ний хооронд даатгуулагчдад олгосон хөнгөлөлтэй эмийн жагсаалтыг нийгмийн даатгалын байгууллагад 2 удаа өгсөнөөс 3.9 сая төгрөгийн санхүүжилт дөвхардсан;

- Наянбулаг ганга, Хонгорхайрхан, Энхтун, Бөмбөгөр, Хүрээмарал, Богд, Баянцагаан сумын 11 эмийн санд олгосон 7.1 сая төгрөгийн эмийн үнийн хөнгөлөлтийн санхүүжилтийг сангийн 2012 оны тайландаа өглөгөөр тусгаагүй атлаа 2013 оны батлагдсан санхүүжилтээс олгосон;

Түүнчлэн эрүүлийг хамгаалах технологи, эмийн жорын маягт, жор бичилт MNS 5376:2008 стандартын 6.2³⁰, 6.6³¹, 6.14³², 7.2³³ дахь заалтуудыг зөрчсөн эмийн жороор хөнгөлөлттэй эм олгосон, ЭМДСЗ-ийн 2011 оны 3 дугаар тогтоолоор батлагдсан “Эрүүл мэндийн даатгалын сангаас зайлшгүй шаардлагатай эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх журам”-ын 1.3³⁴, 3.2³⁵, 3.8³⁶ дахь заалтуудыг зөрчиж эрүүл мэндийн даатгалын хяналтын эмч байцаагчийн хяналтгүйгээр илүү санхүүжилт олгосон, “ЭМДС-аас зайлшгүй шаардлагатай эмийн хөнгөлөлт үзүүлэх журам”-ын 5.3.1³⁷ дэх заалтыг зөрчиж гэрээний үнийн дүнгээс илүү санхүүжилт олгосон зэрэг зөрчлүүд илэрлээ. Тухайлбал:

- Налайх дүүргийн НДХ-ийн ЭМД хариуцсан магадлагч эмч хяналтыг бүрэн хэрэгжүүлэхгүйгээр 1.2 сая төгрөгийн санхүүжилтийг хэтрүүлэн олгосон;

²⁷... Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарыг тасралтгүй сайжруулах чиглэлээр эмнэлгийн чанарын алба /баг/-тай мэдээлэл солилцож замаар хамтран ажиллана.”

²⁸... Тусламж, үйлчилгээний чанарын талаар даатгуулагчдын сэтгэл ханамжийн судалгаа хийх бөгөөд уг судалгааны үр дүн болон даатгуулагчдын санал, хүсэлт, гомдлын талаарх мэдээллийг эмнэлэгт хүргүүлэн, холбогдо арга хэмжээ авч, цаашид анхаарах асуудлаар эмнэлэгтэй хамтран ажиллана.”

²⁹“Эрүүл мэндийн газар тусгай зөвшөөрөл олгосон эмийн сангийн үйл ажиллагааг аттестатчлах ажлыг Нийгмийн даатгалын байгууллагатай хамтран 2 жил тутам дохион байгуулж, дүнг үндэслэн зөвшөөрлийн хугацааг сунгах, түр түдгэлзүүлэх, цуцлах асуудлыг шийдвэрлэх”

³⁰... Эмийн нэрийг олон улсын нэршилээр нь латинаар.. бичнэ”

³¹“Жорыг бэх тоосон балаар тод гаргацтай бичих бөгөөд баллаж засварлаж үл болно”

³²“Жорын маягт бичигдсэн эмийн хооронд тусгаарлах тэмдэг # тавина”

³³“Жорын маягтын ар талд жор хүлээн авсан, бэлтгэсэн, шалгасан, олгосон эм зүйч, эм найруулагч гарын үсгээ зурж огноог тэмдэглэнэ”

³⁴Эрүүл мэндийн даатгалын сангаас зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтад заасан эмийг хөнгөлөлттэй үнээр олгоход Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль, Эмийн жор, жорын маягт, жор бичилт, MNS 5376:2008 стандарт, эмийн санд тавих нийтлэг шаардлага MNS 5260:2011 стандарт, ЭМДСЗ-ийн 2011 оны 02 тоот тогтоолоор баталсан “ЭМДС-аас үнийн хөнгөлөлт үзүүлэх эмийн жагсаалт, хөнгөлөх хувь, хэмжээ” энэ журам болон холбогдо бусад хууль тогтоомжийг мэддэне...

³⁵... ЭМДС-аас үнийн хөнгөлөлт үзүүлэх эмийг энгийн эмийн жорын маягтад бичнэ. Эмийн жорын нэг маяг дээр турваас илүүгүй нэр төрлийн эмийг эмийн ерөнхий нэршилээр бичнэ. Эмийн жорыг ерөнхий нэршилээр бичээгүй тохиолдолд ЭМДС-аас хөнгөлөлт үзүүлэхгүй...”

³⁶... Эмийн жорыг батлагдсан маягтаар бичээгүй, эмийн нэр, тун хэмжээ буруу, алдаатай бичсэн, засварласан болон тамга тэмдэг, код, гарын үсэгтүү, гаргацгүй бичсэн тохиолдолд жорыг хүчингүй тооцож эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжилт олгохгүй.”

³⁷“Хөнгөлөлттэй эмээр үйлчилхээр сонгогдсон эмийн сангуудтай даатгалын гэрээ байгуулж, гэрээний хэрэгжилтийг хангуулан, үр дүнг тооцох

- Дорноговь аймгийн төвийн 5 эмийн сан хөнгөлөлттэй үнийн жор бичих эрхгүй эмчийн бичсэн жороор 3.0 сая төгрөгийн эмийн үнийн хөнгөлөлт олгосон;

- Сэлэнгэ аймгийн Хушаат сумын эмийн санд 0.3 сая төгрөгийн, Түнхэл тосгоны эмийн санд 0.1 сая төгрөгийн зэрэг нийт 0.4 сая төгрөгийн санхүүжилтийг гэрээний үнийн дүнгээс илүү олгосон, Худэр сүм, Дулаанхан, Бугант, Номгон тосгодын эмийн сангуйнад нийт 4.3 сая төгрөгийн санхүүжилтийг нийгмийн даатгалын байгууллага, эмийн сангийн хооронд байгуулсан даатгалын гэрээгүйгээр олгосон;

ИЭМДТХ-ийн 13 дугаар зүйлийн 13.1³⁸, 13.1.1³⁹, 13.1.2⁴⁰-т заасан нөхцөл үүссэн тохиолдолд гэм хор учирсан даатгуулагчийн зардлыг тусламж, үйлчилгээний зардлын төлбөрийг гэм хор учруулсан буруутай этгээдээр төлүүлэхээр заасны дагуу Дорноговь аймагт 28 даатгуулагчийн эрүүл мэндэд гэмт хэрэг зөрчлийн улмаас учирсан хохирлын 3.8 сая, Завхан аймагт гэмт хэрэг зөрчлийн улмаас эрүүл мэндэд учирсан хохирлын 2.4 сая төгрөгийг даатгалын сангаас тус тус нэхэмжилж авсан байна.

Эмийн үнийн хөнгөлөлтийг зөвхөн Өрхийн эрүүл мэндийн төвийн эмчийн бичсэн жороор олгож 2-3 дугаар шатлалын эмнэлгийн эмчийн амбулаторийн үзлэгээр бичсэн эмийн жороор хөнгөлдөггүй нь иргэдийг эмнэлэгт хэвтэн эмнэлгээс үнэгүй эм, тариа хэрэглэх сонирхлыг төрүүлж улмаар эмнэлгийн орыг үр ашиггүй зарцуулахад хүргэж байна.

³⁸ Даатгалын сангаас гарсан зардлыг 13.1.1, 13.1.2-т заасан этгээдээр нөхөн төлүүлэх.

³⁹ Гэмт хэрэг зөрчлийн улмаас эрүүл мэндэд нь гэм хор учирсан даатгуулагчын тусламж, үйлчилгээний зардлын төлбөрийг гэм хор учруулсан буруутай этгээдээр

⁴⁰ Эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн байгууллагын буруутай үйл ажиллагааны улмаас эмчилгээний болон тарилгын дараах хүндэрэл гарсан нь тогтоогдсон тохиолдолд тухайн ЭМБайгууллага.

БҮЛЭГ 2. ТЭТГЭВРИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙН НЭРИЙН ДАНСНЫ ОРЛОГЫН БҮРДҮҮЛЭЛТ, ХУРИМТЛАГДСАН ХӨРӨНГИЙН БАЙДАЛ

Нийгмийн даатгалын шинэчлэлийн хүрээнд УИХ-ын 1999 оны 38 дугаар тогтоолоор батлагдсан төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар 2021 он хүртэл баримтлах үндсэн чиглэл, Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хуульд тэтгэврийн даатгалын нэрийн дансны аргыг сонгох, тэтгэврийн шинэчлэл хийх, хагас хуримтлалын тогтолцоог үе шаттайгаар нэвтрүүлж улмаар бүрэн хуримтлалын тогтолцоонд шилжих, даатгуулагч бүрт нэрийн данс нээх зорилт тавьсан байна.

Одоогийн байдлаар Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансанд даатгуулагчийн төлсөн шимтгэл, хүүгийн орлого хийсвэрээр бүртгэгдсэн, нийгмийн даатгалын сангийн нэгдсэн санхүүгийн тайланд тусгагдаагүй, тэтгэвэр олгох эх үүсвэр бүрдээгүй байна.

2.1. МУ-ЫН ИРГЭНД ТЭТГЭВРИЙН НЭРИЙН ДАНСЫГ НЭЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА

Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хуульд 1960 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр ба түүнээс хойш төрсөн даатгуулагч тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн данстай байхаар, тэтгэврийн нэрийн дансны харилцааг хуулиар зохицуулахаар тус заасан байна.

Тэтгэврийн даатгалын нэрийн дансны 2013 оны мэдээлэл улсын хэмжээгээр эцэслэн бодогдож гараагүй байгаа тул аудитад 2012 оны жилийн эцсийн байдлаарх орлого болон жилийн эцсийн үлдэгдлийг хамруулсан болно.

2012 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 1,107.1 мянган МУ-ын иргэн, 60.5 мянган гадаадын иргэн буюу харьялалгүй иргэн тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансанд бүртгэгдэж данс нээлгэсэн байна.

Орон нутгийн Улсын бүртгэлийн хэлтэсийн үйл ажиллагаанд ашиглагдаж буй цахим мэдээллийн баазын програм хангамж түүний хайлтын системээр тодорхой нэг иргэний овог, нэр эсвэл регистрийн дугаар зэрэг өгөгдлөөр тухайн иргэний мэдээлэл гарч байгаагаас 1960 оны 1 дүгээр сарын 1-ээс хойш төрсөн нийт иргэдийн нэгдсэн тоог нарийвчлан гаргах боломжгүй байна.

Иймд энэ цахим мэдээллийн баазын програм хангамжийг боловсронгуй болгох шаардлагатай байна.

2.2. ТЭТГЭВРИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙН НЭРИЙН ДАНСНЫ ГАРААНЫ ҮЛДЭГДЭЛ ТООЦУУЛЖ БҮРТГҮҮЛЭХ АЖИЛ ЗАРИМ ГАЗАРТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА

Нэрийн дансны эхний /гарааны/ үлдэгдэл тооцох шимтгэлийн хувь хэмжээг НДҮЗ-ийн 2010 оны 02 тоот тогтоолд заасныг баримтлан 19 хувиар, нэрийн дансны эхний үлдэгдэл тооцоход баримтлах 1995-1999 оны цалин хөлсний дундаж итгэлцүүрийг 1995 онд 10.06 хувь, 1996 онд 4.6 хувь, 1997 онд 3.83 хувь, 1997 онд 3.83 хувь, 1998 онд 3.54 хувь, 1999 онд 3.22 хувиар тус тус тооцож бүртгэсэн байна.

Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хуулийн 5 дугаар зүйлд заасны дагуу нэрийн дансны эхний үлдэгдлийг тооцож бүртгэсэн боловч 1960 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хойш төрсөн хөдөлмөрийн насны иргэдийг бүрэн хамруулж дуусаагүй байна. Тухайлбал:

- Дархан-Уул аймгийн Статистикийн хэлтэсийн мэдээгээр тус аймагт 1960 оны 1 дүгээр сарын 1-ээс хойш төрсөн хөдөлмөрийн насны 55266 иргэн байхад 2012 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар дээрх иргэдийн 53.3 хувь буюу 29443 иргэн тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансанд бүртгэгдэж данс нээсэн байна.
- Орхон аймагт шалгалтанд 11-41 ажилтантай 10 байгууллагыг сонгон нийт 231 хүнийг хамруулан түүвэрлэж тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны гарааны үлдэгдэл тооцуулсан байдлыг шалгахад 26.4 хувь буюу 61 иргэн 176.6 сая төгрөгийн гарааны үлдэгдэл тооцуулж, 31.6 хувь буюу 73 иргэн гарааны үлдэгдэл тооцуулаагүй, 42 хувь буюу 97 иргэн гарааны үлдэгдэл тооцуулах шаардлагагүй, 2000 оноос хойш хөдөлмөр эрхэлсэн иргэд байна.

2.3. Ажил олгогчийн төлсөн шимтгэлийг нэрийн дансанд бүртгэж, хууль журмын дагуу хүүгийн орлогыг тооцож байна

Нийгмийн даатгалын шимтгэлийн тооцоог ажил олгогч нь ажиллагсдын цалингийн баримттай тулган баталгаажуулж, ажиллагсад тус бүрийн нэрээр “Нийгмийн даатгалын шимтгэлийн цахим систем 1.0”-д шивэлт хийж бүртгэсний дараа НДХ хуульд заасан хувь хэмжээгээр даатгуулагчийн нэрийн дансанд хуваарилагдан бүртгэгдэж байгаа ч цалин, хөдөлмөрийн хөлс зөрүүтэй шивэгдсэн байна. Тухайлбал:

- Орхон аймгийн тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны мэдээлэх хуудсандаа даатгуулагчийн цалин хөлс түүнтэй адилтгах орлого зөв шивэгдсэн эсэхийг нийгмийн даатгалын дээвтэрт бичигдэж баталгаажсан цалинтай тулган шалгахад 1 хүний 2004 оны 12 дугаар сарын цалин 167.2 мянган төгрөгийг шивж оруулаагүй, нэг хүний 2012 оны 1 дүгээр сарын цалинг 419.4 мянган төгрөгөөр илүү, нэгээг 71.4 мянган төгрөгөөр дутуу, 2 дугаар сарын цалинг 184.1 мянган төгрөгөөр илүү, 3 дугаар сарын цалинг 315.8 мянган төгрөгөөр илүү тус тус зөрүүтэй шивж оруулсан;
- Уес аймагт 7 төсөөт байгууллагын 50 гаруй даатгуулагчийн нэрийн дансны мэдээллийг түүвэрчлэн тулгахад 53.8 хувь буюу 28 хүний нэрийн дансны мэдээлэл дутуу орсон ба ихэвчлэн 2000 он, 2001 оны цалингийн мэдээллүүд ороогүй, 2005-2007 оны зарим сарын мэдээллүүд нь дутуу орсон байна.

НДҮЗ жил бүр даатгуулагчдын тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны орлогод тооцох хүүгийн хэмжээг тогтоож өгсөн байна.

Тогтоосон хүүгийн хэмжээг хүснэгтээр үзүүлбэл:

/хувиар/

Он	2000	2001	2002	2003	2004	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013
Хүүгийн хувь	13.0	14.0	14.0	5.0	11.0	7.0	11.1	15.8	18.7	29.8	28.3	25.4	20.6	22.3

Тэтгэврийн даатгалын нэрийн дансанд бүртгэгдсэн иргэдийн дансан дахь орлогын эхний үлдэгдэл болон тухайн жилд төлсөн шимтгэлийн орлогод хууль, тогтоомжинд заасан хувь хэмжээгээр хүүгийн орлогыг тооцож байгаа эсэхэд түүвэр шалгалт хийж хүүг тооцож үзэхэд хууль тогтоомжинд заасан хувь хэмжээг баримтлан үнэн зөв тооцож бүртгэсэн байна.

НДҮЗ-ийн 2014 оны 24 дүгээр тогтоолоор 2013 оны шимтгэлийн орлогод тооцох хүүгийн хувь хэмжээг 22.3 хувиар тогтоосон ба ТДШНД-ны 2013 оны хүүгийн орлогыг тооцох, нэрийн дансанд бүртгэх ажлыг зохион байгуулж байна.

2.Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансанд хуримтлагдсан мөнгөн хөрөнгө хийсвэрээр бүртгэгдэж байна

Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансанд зохих хууль тогтоомж, журмын дагуу тооцогдож хуримтлагдсан эхний үлдэгдэл, түүний хүүгийн орлого, бүртгэсэн тэтгэврийн даатгалын шимтгэл, түүний хүүгийн орлогоос бүрдсэн нийт

6,876.6 сая төгрөгийн мөнгөн хөрөнгө 2013 оны нийгмийн даатгалын сангийн нэгдсэн санхүүгийн тайланд тусгагдаагүй, хийсвэрээр бүртгэгдсэн байна.

“Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар 2021 он хүртэл баримтлах үндсэн чиглэл”, “Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хууль”-д тэтгэврийн даатгалын нэрийн дансны аргыг сонгох, хагас хуримтлалын тогтолцоонд үе шаттайгаар, аажимдаа бүрэн хуримтлалын тогтолцоонд шилжих, даатгуулагч бүрт хийсвэр тооцооллын арга бүхий нэрийн данс нээх зэрэг зорилтыг тодорхойлсон боловч гол зорилтууд хэрэгжээгүй, хэрэгжих нийгэм эдийн засгийн нөхцөл өнгөрсөн хугацаанд бүрдээгүй байна.

Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансанд мөнгөн хөрөнгийг бодитой хуримтлуулаагүйн улмаас Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хуулийн 7 дугаар зүйлийн заалтууд хэрэгжих боломжгүй байна.

БҮЛЭГ 3. САНГУУДЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИХ ХЯНАЛТ

3.1. ЭМДС-ийн үйл ажиллагаанд тавих хяналтын дүрмийн зарим заалтыг хэрэгжүүлээгүй, Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хуулийн хэрэгжилтэд тавих хяналт хангалтгүй байна

МУЗГ-ын 1998 оны 239 дүгээр тогтоолоор батлагдсан Иргэний эрүүл мэндийн даатгалын хяналтын дүрэмд заасан чиг үүргийн дагуу НДХ-ийн ЭМД-ын улсын байцаагчид эрүүл мэндийн тусlamж үйлчилгээнд хамрагдаж буй даатгуулагчийн эрүүл мэнд, нийгмийн даатгалын дэвтэр олгох, бүртгэх, баталгаажуулах, даатгуулагчийн мэдээллийг цахим санд үнэн зөв бүртгэх, ногдуулалт хийх, амбулаторийн болон хэвтэн эмчлүүлэх тусlamж үйлчилгээ, эмийн үнийн хөнгөлөлтийн зардалд хяналт тавьж ажиллах зэрэг чиг үүргийг хэрэгжүүлж байна.

НДЕГ нь эрүүл мэндийн байгууллагуудаас ирүүлсэн даатгуулагчдад үзүүлсэн тусlamж, үйлчилгээний зардлын төлбөрийн нэхэмжлэлийг ЭМД-ын мэдээллийн санд хянан бүртгэхдээ өвчний онош, оношийн бүлгийн зөрүү, эмчилгээ, үйлчилгээ авсан хугацааны давхардал, даатгуулагчийн бүртгэлтэй эсэх зэргийг цаасан болон цахим хэлбэрээр шалгаж төлбөр тооцог хийдэг.

Эдгээр шалгааны улмаас 2013 онд нийт 61039 даатгуулагчийн 1,595.2 сая төгрөгийн тусlamж, үйлчилгээний зардлын төлбөрийг эрүүл мэндийн байгууллагуудын нэхэмжилсэн дүнгээс хасаж олгосон бөгөөд НДЕГ-ын дэргэдэх ЭМДГ-ын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэс нь 2013 онд эрүүл мэндийн байгууллагуудад ЭМДС-гаас олгох тусlamж, үйлчилгээний зардлын төлбөрийн энхүү хасагдалд дотоодын шалгала хийж, цаашид анхаарах асуудлаар холбогдох эрүүл мэндийн байгууллага, эмч, мэргэжилтэнүүдэд мэргэжил арга зүйн зааварчилгаа өгч ажилласан байна.

НДЕГ-ын дэргэдэх ЭМД-ын газрын хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэсээс 2013 оны байдаар хасагдсан 2395 даатгуулагчийн мэдээллийг шалгахад ЭМДШ төлсөн 1155, төр хариуцах 178, гадны даатгуулагч 121, регистрийн дугаар алдаатай 115 буюу нийт 1569 даатгуулагчийн мэдээллийг төлбөр тооцоо хариуцсан мэргэжилтнүүд программ хангамжид эрүүл мэндийн байгууллагаас ирүүлсэн мэдээллийг дутуу шалгаснаас эрүүл мэндийн байгууллагуудын санхүүжилтээс хасч тооцсон зэрэг зөрчлийг илрүүлж ажилласан байна.

2013 онд НДЕГ-аас орон нутаг дахь НДХ-тэй хамтран хийсэн шалгалтаар Орхон аймгийн 649 даатгуулагчийн 24.1 сая төгрөгийн эрүүл мэндийн тусlamж үйлчилгээг алдаатай буруу нэхэмжилж авсныг төлбөрийн акт тогтоож төлүүлсэн байна.

Аудитын явцад ЭМДС-ийн үйл ажиллагаатай холбоотой нийт 1.7 тэрбум төгрөгийн зөрчил илэрч байгаа нь НДЕГ-ын ЭМДС-ийн зарцуулалтад тавих дотоод хяналт хангалтгүй байгааг харуулж байна.

Аудитаар илэрсэн 16.3 сая төгрөгийн зөрчилд 12 акт, 1,274.0 сая төгрөгийн зөрчлийг арилгуулахаар 12 албан шаардлага, хариуцлага тооцохоор 6 албан шаардлага өглөө.

ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- НДҮЗ-ийн 2013 оны 1 дүгээр тогтоолоор “Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дэргэдэх эрүүл мэндийн даатгалын салбар зөвлөлийн ажиллах журам”-ыг хүчингүй болгосон, шинэчилсэн журам боловсруулагдаагүй байгаа тул бүх аймаг, нийслэлд ЭМД-ын орон тооны бус салбар зөвлөл үйл ажиллагаа явуулаагүй байна.
- Эрүүл мэндийн даатгалд хамрагдвал зохих нийт даатгуулагчдын 97.7 хувь нь хамрагдсан, даатгуулагчийг эрүүл мэндийн үзлэгт урамшууллаар хамруулах ажил хангалтгүй байна.
- ЭМС, СС, НХХС нар 2013 онд даатгуулагчид үзүүлэх тусlamж үйлчилгээний хувьсах зардлын хэмжээг шинэчлэн тогтоогоогүй нь ИЭМДТ хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх заалтыг хэрэгжүүлээгүй байна.
- ЭМДС-аас эмнэлгүүдэд олгож байгаа санхүүжилт нь эмнэлгүүдийн хүрэлцэхгүй байгаа зардлын зүйлийг санхүүжүүлэхэд ашиглагдаж байгаа тул эмнэлгийн тусlamж үйлчилгээний чанарыг сайжруулах хэрэгсэл болж чадахгүй байна.
- Эрүүл мэндийн тусlamж үйлчилгээний багц нь даатгуулагчийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн тусlamж үйлчилгээг бүрэн хамардаггүй, даатгуулагч олон төрлийн шинжилгээ, оношилгооны төлбөрийг өөрөөсөө төлж байгаа нь тэдний эрх ашигт нийцэхгүй байна.
- Эрүүл мэндийн даатгалын бодлого, төлөвлөлт, үүрэг, хариуцлагын асуудлыг ХАХНХЯ, ЭМЯ, НДҮЗ, ЭМДСЗ-ийн дунд тарааж хуваагдмал болгосноор эрүүл мэндийн даатгалын тогтолцооны цогц байдал алдагдаж, даатгалын байгууллага даатгуулагчийг төлөөлөн эрүүл мэндийн чанартай тусlamж үйлчилгээг худалдан авах чиг үүргээ хэрэгжүүлэхгүй зөвхөн санхүүжүүлэгчийн үүрэг гүйцэтгэж байна.
- Иргэний нэрийн дансанд мөнгөн хөрөнгийг бодитой хуримтлуулахгүй байгаагаас “Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай” хуулийг хэрэгжүүлэх нөхцөл бүрдээгүй байна.
- Иргэний эрүүл мэндийн даатгалын хяналтын улсын байцаагч нар ИЭМДТ хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх заалт, Эрүүл мэндийн даатгалын хяналтын дүрэмд заасан үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй, НДЕГ-ын ЭМДС-ийн зарцуулалтад тавих дотоод хяналт хангалтгүй байна.

**Эрүүл мэндийн даатгал, Иргэний нэрийн дансанд
хуримтлагдсан хөрөнгийн байдал**



**МОНГОЛ УЛСЫН ХУН АМЫН ХӨГЖИЛ,
НИЙГМИЙН ХАМГААЛЫН ЯМ**

15160 Улаанбаатар хот, Чингисийн дүүрэг,
Нийдэлийн улсын тутамжийн төслийн
Фондийн зорилтуудын төслийн тутамжийн
Фондийн зорилтуудын төслийн тутамжийн
Цахим хурдас: www.mpdsp.gov.mn

2014.10.10 № 311936.

таний _____ -ны № _____ -т

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ

2014 оны 9 дүгээр сарын 18-ны өдрийн 1109 тоот албан бичгээр ирүүлсэн "Эрүүл мэндийн даатгал, Иргэний нэрийн дансанд хуримтлагдсан хөрөнгийн байдал"-д хийсэн аудитын тайланд дараах саналыг хүргүүлж байна.

Санал болон тайлбарыг хавсаргав.

ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Б.ОТГОНЖАРГАЛ



MPDSP-2014 /Jijig Blank - 10 Sat

Тайлбар, санал хургуулэх тухай

Үндэсний аудитын газрын Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай болон Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хууль, тогтоомжийг 2013 онд хэрэгжүүлсэн байдалд хийсэн аудитын урьдчилсан тайланг хүлээн авч танилцан дараах тайлбар, саналыг хургуулж байна.
Үүнд:

**НЭГ. ИРГЭНИЙ ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛЬ,
ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТ**

Тайлбар :

- Наянбулаг ганга, Хонгорхайрхан, Энхтун, Бөмбөгөр, Хүрээмжарал Бодг, Баянцагаан сумын 11 эмийн санд олгосон 7,1 сая төгрөгийн эмийн үнийн хөнгөлөлтийн санхүүжилтийг сангийн 2012 оны тайландаа өвлөгөөр тусгаагүй атлаа 2013 оны батлагдсан санхүүжилтээс олгосон гэсэн хэсэгт /худас15/

Тайлбар 1.1. Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-т "... даатгуулагчийн тусlamж, үйлчилгээний зардлын ... гүйцэтгэлийг дараа сарын 25-ны дотор тооцон олгоно." гэж заасны дагуу дээр дурдсан эмийн сангуудын 2012 оны 12 дугаар сарын сүүлээр даатгуулагчдад үзүүлсэн эмийн үнийн хөнгөлөлтийн зардлыг 2013 оны 1 дүгээр сард олгосон болно.

Санал :

- Аудитын дүгнэлтийн нүүр хуудасны "Эрүүл мэндийн датгал, Тэтгэврийн нэрийн дансны тухай хууль, тэдгээрийн үйл ажиллагаатай холбогдон гарсан журмын хэрэгжилт хангалтгүй байна." гэснийг

Санал 1.1: Иргэний эрүүл мэндийн даатгалын болон Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн данстай холбогдолтой хууль эрх зүйн орчныг сайжруулах гэж;

Аудитын Зөвлөмжид дараах нэмэлт оруулах:

Санал 1.2:

Сангийн сайдад:

Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4-т заасны дагуу сангийн чөлөөт үлдэгдлийн хүүгийн хэмжээг арилжааны банкны хуугийн жилийн дундаж хэмжээтэй уялдуулан тооцож, сангийн чөлөөт үлдэгдэл хөрөнгийг үнэгүйдлээс хамгаалах нөхцелийг бурдуулэх гэсэн зөвлөмж нэмэх.

**ХОЁР. ТЭТГЭВРИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙН НЭРИЙН ДАНСНЫ
ТУХАЙ ХУУЛЬ, ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТ**

1. Хуудас 1-д Агуулга бүлэг- 2 хэсэгт байгаа хэллэгийг гарчигийн хэллэг болгох

Жишээ нь: Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хуулийн хэрэгжилт

- 1.1. Даатгуулагчид нэрийн данс нээх ажлын явц
- 1.2. Нэрийн дансны орлогын эх үүсвэр, гарч байгаа асуудал
- 1.3. Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны эхний үлдэгдлийг тооцож бүртгэх ажлын талаар
- 1.4. Ажил олгогч, даатгуулагчаас төлсөн шимтгэлийг нэрийн дансанд бүртгэж, хуулийн дагуу хүүгийн орлого тооцох ажлын талаар
- 1.5. Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансанд хуримтлагдсан хөрөнгийн бүртгэлийн тухай

2. хуудас 1: НДЕГ-ын МТТ-өөс гадаадын иргэн буюу харьялалгүй иргэний тоон судалгааг гаргаж, энэхүү судалгааг гаргаж hongor_nm@yahoo.com хаягаар явуулсан тул "НДХ-ээс гаргах боломжгүй байна" гэдгийг хасах

3. хуудас 19: 2013 оны хүүгийн орлогыг тооцоогүй, нэрийн дансанд хуримтлуулаагүй байна." гэдгийг "...22.3 хувиар тогтоосон ба ТДШНД-ны 2013 оны хүүгийн орлогыг тооцох, нэрийн дансанд бүртгэх ажлыг зохион байгуулж байна" гэж өөрчлөх.

Хуудас 19 –д дараах мэдээллийг оруулах

"Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар 2021 он хүртэл баримтлах үндсэн чиглэл", "Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хууль"-д тэтгэврийн даатгалын нэрийн дансны аргыг сонгох, хагас хуримтлалын тогтолцоонд үе шаттайгаар, аажимдаа бүрэн хуримтлалын тогтолцоонд шилжих, даатгуулагч бүрт хийсвэр тооцооллын арга бүхий нэрийн данс нээх зэрэг зорилтыг тодорхойлсон боловч гол зорилтууд хэрэгжээгүй, хэрэгжихийн нийгэм, здийн засгийн нөхцөл өнгөрсөн хугацаанд бүрдсэнгүй. Тухайлбал,

- Үндсэн чиглэлд тэтгэврийн даатгалын шимтгэл 19 хувь байгааг хэвээр мөрдөх, 2005 оноос даатгуулагчийн төлсөн шимтгэлийн 3 хүртэл хувийг хуримтлалд оруулах, энэ хэмжээг цаашид нэмэгдүүлэх бодлогууд хэрэгжээгүй төдийгүй, шимтгэлийн хэмжээг 5 хувиар бууруулсан, тэтгэврийн хэмжээг улс төрийн шалтгаанаар удаа дараа нэмэгдүүлсэн, 1995 оноос хойш тогтоогдсон тэтгэврийг 1960 оноос хойш төрсөн одоогийн даатгуулагч, ажил олгогчдын төлсөн шимтгэлээс олгож байгаа зэргээс шалтгаалан тэтгэврийн даатгалын тогтолцоонд гажуудал үүсч, сангийн алдагдал ихэсч, тэтгэврийн даатгалын санд олгох төсвийн санхүүжилт жил бүр нэмэгдсэн;

- Хуваарилалтын тогтолцооны нэг хэлбэр болсон нэрийн дансны тухай олон нийтэд үнэн зөв мэдээлэл өгөх ажил шаардлагын түвшинд хүрээгүйгээс нэрийн дансны хийсвэр тооцоог бодит мөнгөн хуримтлал гэж ойлтон, түүнийг хөрөнгө оруулалтад оруулах, өвлүүлэх зэргээр захиран зарцуулах эрхтэй гэсэн төсөөлөлд хүргэсэн байна.

Түүнчлэн нэрийн данснаас тогтоолгох тэтгэврийн хэмжээ, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн дагуу тогтоогдох тэтгэврээс 30 хувиар бага байх урьдчилсан тооцоо гарсан;

- Хүн амын бүтцийн хувьд харьцангуй тааламжтай байгаа энэ үед малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, албан бус салбарт ажиллагдын хамралт хангалттай бус;

- 2020 оноос хойш хүн ам насжих, ахмад настны эзлэх хувь нэмэгдэн, ялангуяа 1960-1970 оны хүн амын огцом өсөлтийн үеийнхэн олноор тэтгэвэрт гарах үед тэтгэврийн даатгалын одоогийн тогтолцоо үйлчилж чадахгүй нөхцөл байдал үүсэхээр байна.

Дээрх шалтгааны улмаас Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хуулийг 2015 оноос эхлэн хэрэгжүүлэх боломжгүй болоод байна.

Иймд яаралтай авч хэрэгжүүлэх шаардлагатай дараах арга хэмжээний саналыг хургуулж байна. Үүнд:

1. “Төреөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах үндсэн чиглэл”-ийг шинэчлэн боловсруулж, Улсын Их Хурлаар батлуулах;

2. Нийгмийн даатгалын тухай хуулийг шинэчлэн боловсруулж, батлуулах;

3. Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хуулийг шинэчлэн боловсруулж, уг хуульд нийгмийн даатгалын тогтолцоонд шилжсэн 1995 онд хөдөлмөрийн насанд хурсэн иргэд буюу 1979 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр ба түүнээс хойш төрсөн иргэдийг хамруулах, тэдгээрийн бүртгэлийг дааттуулагч тус бүрээр хийж, данс бүртгэлд тусгах;

4. 1979 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр ба түүнээс хойш төрсөн дааттуулагчийн төлсөн шимтгэлийг бодитоор хуримтлуулж, хөрөнгө оруулалтад оруулах замаар өсгөн нэмэгдүүлэх эрх зүйн орчин бүрдүүлэх;

5. Дааттуулагчийн төлсөн шимтгэлийг бодитоор хуримтлуулж эхлэхтэй холбоотойгоор одоогийн тэтгэвэр авагчдын тэтгэврийг олгох хөрөнгийг улсын төсөв болон байгалийн баяглаас бий болгосон тусгай сангаас санхүүжүүлэх зохицуулалт хийх бэлтгэл ажлыг хангах;

6. Нийгмийн даатгалын тухай хууль батлагдахаас өмнө буюу 1995 оноос тэтгэвэрт гарсан иргэдийн тэтгэвэрт олгосон болон тэтгэвэр олгох үйл ажиллагааны зардлыг улсын төсвөөс нийгмийн даатгалын санд нөхөн олгох зохицуулалт хийх;

7. Нийгмийн даатгалын тогтолцоог хөгжүүлэх, нийгмийн даатгалын сангийн бие даасан байдлыг хангах, нийгмийн даатгалын байгууллагын статус, үйл ажиллагааг оновчтой болгох хууль эрх зүйн орчин бүрдүүлэх.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг доорхи албан тушаалтнуудад хүргүүлж байна.

Засгийн газарт:

- Иргэний нэрийн дансанд тооцсон орлогыг бодитой мөнгөн хөрөнгөөр бүрдүүлж, баталгаажуулах асуудлыг шийдвэрлэх арга хэмжээ авах;

Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлд:

- Даатгуулагчдад үзүүлэх тусlamж үйлчилгээний хувьсах зардлын хэмжээг ИЭМДТ хуульд заасны дагуу шинэчлэн тогтоох;
- Даатгалын байгууллага эрүүл мэндийн байгууллагуудтай хамтран уялдаатай ажиллаж, даатгуулагчид үзүүлж буй эрүүл мэндийн тусlamж үйлчилгээний чанарт үнэлгээ шинжилгээ хийж санхүүжүүлэх асуудлыг судалж шийдвэрлэх;
- Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хуулийг дагаж мөрдөх журмыг боловсронгуй болгож, шинэчлэх;
- Нийгмийн даатгалын нэрийн дансны үйл ажиллагаанд ашиглагдаж буй цахим мэдээллийн бааз, програм хангамж түүний хайлтын системийн мэдээлэлийг орон нутагт нээлттэй харах боломжийг бүрдүүлэх;

НДҮЗ-ийн дэргэдэх Эрүүл мэндийн даатгалын салбар зөвлөлд:

- Эрүүл мэндийн даатгалын орон тооны бус салбар зөвлөлийн ажиллах журмыг хуульд заасны дагуу шинэчилж, зөвлөлийн ажиллах нөхцөлийг бүрдүүлэх;
- ЭМДС-ийн орлого зарлагын төлөвлөлтийг сайжруулах, зардлыг оновчтой болгох, үр дүнг дээшлүүлэх чиглэлээр холбогдох арга хэмжээ авах.

НДЕГ-ын дарга Ц.Уртнаасанд:

- Эрүүл мэндийн даатгалд хамрагдалтыг нэмэгдүүлэхийн тулд баг, хорооны Засаг дарга, Иргэний бүртгэл, Татварын байгууллага, их, дээд сургууль, МСҮТ, болон хувийн хэвшил, төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллаж шимтгэл цуглуулах үйл ажиллагааг сайжруулах;
- Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хууль, эрүүл мэндийн даатгалын багц үйлчилгээ, эмийн үнийн хөнгөлөлтийн талаар иргэд, олон нийтийг тасралтгүй мэдээллээр хангах тогтолцоог бий болгох;
- ЭМДС-ийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалтад тавих дотоод хяналт, шалгалтыг сайжруулж ажиллах;

Холбогдох байгууллагын саналд өгөх тайлбар

Тайлбар 1-д: Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-т заасан үндэслэлээр Баянхонгор аймгийн Наянбулаг ганга, Хонгорхайрхан, Энхтун, Бөмбөгөр, Хүрээмараал, Богд, Баянцагаан сумын 11 эмийн санд олгосон 7.1 сая төгрөгийн эмийн үнийн хөнгөлтийн санхүүжилтийг сангийн 2012 оны тайландаа өглөгөөр тусгаагүй атлаа 2013 оны батлагдсан санхүүжилтээс олгосон гэснийг хассан болно.

Санал 1-д: Агуулгын 2 дугаар хэсгийн заалтуудыг гарчигийн хэллэг болгох гэсний дагуу тайландаа нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагагүй.

Санал 2-д: Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн данс нээлгэсэн гадаадын иргэн буюу харьялалгүй иргэний тоон мэдээллийг аймаг бүрээр нь гаргаж ирүүлсэн тул тайлангийн хоёрдугаар бүлгийн 2.1 дэх хэсгийн 17 дугаар хуудасны найруулгыг өөрчиллөө.

Санал 3-д: Ирүүлсэн саналыг хүлээн авч тайлангийн хоёрдугаар бүлгийн 2.4-д дараах найруулгыг хийлзээ.

НДҮЗ-ийн 2014 оны 24 дүгээр тогтоолоор 2013 оны шимтгэлийн орлогод тооцох хүүгийн хувь хэмжээг 22.3 хувиар тогтоосон ба ТДШНД-ны 2013 оны хүүгийн орлогыг тооцох, нэрийн дансанд бүртгэх ажлыг зохион байгуулж байна.

**Эрүүл мэндийн даатгал, Иргэний нэрийн дансанд
хурумтлагдсан хөрөнгийн байдал**

Эрүүл мэндийн дааталын сантийн 2013 оны оролтын төвлөгөөний билэлт /Хөхсрэлт/

№	Хийтоуда	Төлөвлөгөө шүүхийн эрэгтэй	Ажилт олголчийн төлөвнэ давтгал	Гүйцэтгэл						Сая.тгт
				ХХЭ иргэн, мэдличин, сургацаадын шишгэл	Төр харчуудын изгээдийн шишгэл	Нийт шамыгтайж өсөгдэл	Алданыг экт.	Хүү бүсэд	Бүтэц	
1	Ариунтай	2,186,443.10	1,748,028.70	154,562.10	310,344.00	2,212,334.80	3,456.70	14,018.80	12,785.30	2,230,558.27
2	Баян-Өлгий	2,678,931.50	2,312,640.00	91,659.30	389,940.00	2,794,239.30	6,975.50	2,491.80	1,797.80	2,803,801.74
3	Баянхонгор	2,391,017.70	1,827,175.80	146,211.50	384,312.00	2,357,793.30	3,873.10	852.2	6,608.80	520.4
4	Булган	1,844,198.30	1,561,363.60	95,052.50	125,424.00	1,782,340.10	6,148.00	1,199.80	4,632.20	158.2
5	Голын-Алтай	1,941,334.70	1,844,383.20	94,437.20	229,944.00	2,168,754.40	5,705.60	1,563.70	12,899.70	361.7
6	Дорноговь	4,026,445.30	3,647,334.60	117,670.10	240,396.00	4,005,400.70	2,818.50	315.4	7,446.50	786.6
7	Дорнод	3,153,261.70	2,694,970.20	120,819.60	299,892.00	3,115,681.80	1,784.50	1,304.20	3,915.90	23,714.10
8	Дундговь	1,466,653.20	1,159,378.00	85,194.50	200,196.00	1,444,758.50	672	336.1	2,566.40	8,214.60
9	Завхан	2,347,698.00	2,096,029.60	93,880.20	134,268.00	2,324,877.70	1,501.10	776.4	7,953.00	439.3
10	Өвөрхангай	3,210,263.10	2,341,261.00	257,965.80	667,320.00	3,265,916.30	5,491.10	2,713.40	15,345.60	7,555.00
11	Өмнөговь	4,303,031.00	4,103,430.80	89,837.40	291,048.00	4,484,216.10	2,622.30	178.7	13,158.20	594.4
12	Сүхбаатар	2,092,349.00	1,691,812.00	97,169.80	260,496.00	2,049,477.70	3,320.90	3,942.40	6,659.60	46.2
13	Сэлэнгэ	4,606,312.00	3,663,603.10	154,391.70	508,128.00	4,326,722.80	6,325.50	3,006.20	52,453.80	4,363.90
14	Төв	3,002,267.00	2,451,903.10	125,143.20	464,712.00	3,081,758.30	6,062.80	2,676.50	24,203.50	358.7
15	Ус	2,647,129.00	2,096,858.30	119,669.40	386,724.00	2,603,251.70	2,318.40	761.7	1,452.60	555
16	Хөхд	2,781,341.90	2,387,828.80	112,754.60	310,344.00	2,810,327.40	4,421.30	2,025.00	16,539.80	498.6
17	Хөхслөл	3,278,168.20	2,677,318.40	249,320.10	600,588.00	3,527,726.50	8,131.50	2,752.80	2,880.40	0.1
	Орон нутаг	69,655,956.10	57,266,574.00	2,633,409.70	7,063,944.00	66,363,927.70	92,724.90	41,626.20	308,891.90	82
	Нийслэл	126,974,728.30	111,094,420.80	2,018,667.70	5,087,556.00	118,200,644.50	497,606.70	266,598.60	234,297.60	24,763.00
	НДДГ	5,699,375.70				-			17,152,563.30	108,235.40
	Бүтэц	202,330,060.10	165,360,934.60	4,652,077.40	12,151,500.00	185,164,572.20	590,331.60	308,224.80	17,695,752.80	82
									195,319.60	203,954,283.09
										100.8

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2013 ОНЫ ЗАРДЛЫН ТЕСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

	Хэлтсийн Халтсауд	2013 оны зардлын төлөвлөгөө	Эмнэлгүүдэд олгосон нийт зардал	Сувилалд олгосон нийт зардал	Эмийн сан	Бусад зардал	Нийт зардал	Хавсралт №2
1	Архангай	2,671,601.8	2,179,182.3	176,056.0	194,610.3	93,905.1	2,643,753.7	
2	Баян-Өлгий	1,720,545.7	2,063,533.4	53,280.0	182,168.8	97,774.5	2,396,756.7	
3	Баянхонгор	3,150,147.3	2,304,883.1	357,420.0	291,103.4	96,744.6	3,050,151.1	
4	Булган	1,652,687.0	1,226,363.8	-	153,660.6	87,818.0	1,467,842.3	
5	Говь-Алтай	2,031,715.8	1,762,067.4	62,678.0	126,582.5	95,385.0	2,046,712.8	
6	Дорноговь	1,891,622.5	1,593,069.8	39,072.0	196,344.6	87,538.8	1,916,025.2	
7	Дорнод	2,634,857.3	2,352,299.5	-	238,315.1	110,093.4	2,700,708.0	
8	Дундговь	1,602,686.0	1,254,055.6	35,742.0	204,036.1	99,489.0	1,593,322.7	
9	Завхан	1,844,800.4	1,452,839.1	50,912.0	244,031.8	110,121.6	1,857,904.5	
10	Өвөрхангай	4,066,827.5	2,365,065.4	1,127,538.0	420,154.0	120,282.5	4,033,039.8	
11	Өмнөговь	1,268,774.9	1,019,980.0	-	184,346.3	173,146.4	1,377,472.8	
12	Сүхбаатар	1,652,687.0	1,390,603.9	-	208,015.4	77,862.0	1,676,481.3	
13	Сэлэнгэ	2,502,896.8	2,318,281.8	-	142,969.7	118,963.0	2,580,214.6	
14	Төв	2,227,091.3	1,482,037.2	370,674.0	259,390.7	185,951.0	2,298,052.9	
15	Увс	2,255,015.6	1,837,487.7	-	290,152.6	91,141.2	2,218,781.5	
16	Ховд	3,511,922.2	3,225,024.8	-	245,683.1	98,085.1	3,568,793.0	
17	Хөвсгөл	3,550,795.1	3,056,402.8	79,920.0	389,840.6	120,277.3	3,646,440.7	
18	Хэнтий	2,365,537.1	1,808,546.1	291,930.0	135,663.0	107,878.2	2,344,017.3	
19	Дархан-Уул	3,123,518.9	2,756,979.0	-	338,570.7	110,656.5	3,206,206.2	
20	Орхон	3,323,369.5	2,842,359.5	120,244.0	258,756.9	95,328.1	3,316,688.6	
21	Говьсумбэр	800,748.3	711,705.4	-	76,645.2	137,779.5	926,130.2	
	Орон нутаг	49,849,848.0	41,002,767.5	2,765,466.0	4,781,041.6	2,316,220.8	50,865,495.8	
22	Улаанбаатар	4,297,480.6	3,187,439.3	137,196.0	817,913.1	1,119,668.5	5,262,216.9	
23	НДЕГ	71,856,307.7	62,477,697.7	1,440,843.8	4,127,033.2	1,322,043.9	69,367,618.5	
24	НДҮЗ					47,914.2	47,914.2	
	Нийт	126,003,636.4	106,667,904.5	4,343,505.8	9,725,987.8	4,805,847.4	125,543,245.5	



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН ТУШААЛ**

2014 оны 11 сарын 07 өдөр

Дугаар 318

Улаанбаатар хот

Г Аудитын тайланг баталгаажуулах
тухай

"Төрийн аудитын тухай" хуулийн 13 дугаар зүйлийн 13.4.5, "Гүйцэтгэлийн шалгалтын журам"-ын 23 дугаар зүйлийн 23.2, "Гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журам"-ын 4.2-т заасныг үндэслэн ТУШААХ нь:

1. "Эрүүл мэндийн даатгал, Иргэний нэрийн дансанд хуримтлагдсан хөрөнгийн байдал"-д хийсэн аудитын тайланг баталсугай.
2. Аудитын тайланг УИХ-ын Төсвийн байнгын хороо, Хүн амын хөгжил, Нийгмийн хамгааллын яам, Нийгмийн даатгалын Үндэсний Зөвлөл, Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлсүгэй.
3. Аудитын тайланд дурьдагдсан зөрчлүүдийг арилган, өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, үр дунг 2014 оны 12 дугаар сарын 25-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлд зөвлөсүгэй.
4. Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Үндэсний аудитын газрын Дэд дарга, тэргүүлэх аудитор /Б.Баттуяа/, Нийцлийн аудитын газар /Б.Алтанзул/ нарт үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



А.ЗАНГАД